



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-33
1.Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.05.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	6-9
2.“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ./	9-33

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
05 дугаар сарын 20-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 42 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Цогтбаатар, Ө.Шижир, Ж.Энхбаяр;
Чөлөөтэй: Н.Алтаншагай, Э.Бат-Амгалан, Б.Батбаатар, П.Наранбаяр, Н.Номтойбаяр, Х.Тэмүүжин, Б.Энхбаяр, Д.Энхтүвшин.

Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл хэлэлцэх асуудлын дарааллын 2 дугаарт байгаа Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг эхэлж хэлэлцье гэсэн горимын санал гаргав.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабылын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 6

Бүгд: 13

53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг эхэлж хэлэлцэхээр тогтов.

Нэг.Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.05.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Гэр бүл, хөдөлмөр,

нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын Хуримтлалын нэгдсэн сангийн хэлтсийн дарга А.Хишигбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Л.Батмөнх, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг батлахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. *“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгааллын сайд С.Бямбацогт, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, мөн яамны Бодлогын газрын дэд дарга Д.Бямбадорж, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбат, мөн газрын ахлах мэргэжилтэн З.Райымбек, Салбар дундын зохицуулалт, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнгөнсүх, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Г.Отгонцэцэг, Макро эдийн засгийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Энх-Амгалан, мөн газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Мягмардорж, Шинжлэх ухаан,

технологийн нэгдсэн бодлогын газрын дарга Д.Баттогтох, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, мөн газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга О.Мөнхтөр, Хяналт, шинжилгээ, үнэлгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Өнөржаргал, Хөгжлийн төслийн бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Балчинлуvsан, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн газрын Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн шинжээч Т.Хонгор, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, мөн газрын Санхүү, ар талын газрын дарга Б.Баянмөнх, Цөмийн энергийн комиссын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Г.Манлайжав нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Л.Батмөнх, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл, С.Эрдэнэболд, Э.Болормаа, Ч.Анар, Н.Батсүмбэрэл, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 2 дугаар заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл, Н.Батсүмбэрэл, Г.Хосбаяр нарын тавьсан асуултад Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Эрдэнэбат, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал нар хариулж, тайлбар хийв.

Төслийн 3 дугаар заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 4 дүгээр заалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар үг хэлэв.

Тогтоолын төслийг заалт бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 28 минут үргэлжилж, 25 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр 15 цаг 10 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Үндсэн хууль” танхим 13 цаг 42 минут

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Байнгын хорооны ирц бүрдсэн байна. Гишүүдийн ирцийг танилцуулъя. Очирбатын Амгаланбаатар гишүүн, Чинбатын Анар гишүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Энхбатын Болормаа гишүүн, Дашдондогийн Ганбат гишүүн, Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн, Хажикбэрийн Жангабыл, Батбаярын Жаргалан, Нанзадын Наранбаатар, Ганбатын Хосбаяр, Сүхбаатарын Эрдэнэболд, Арвижихын Эрдэнэбүрэн гишүүд хүрэлцэн ирснээр 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаан ирц бүрдэж нээж байгааг мэдэгдье ээ.

Та бүхэнд хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал байгаа.

Нэгдүгээрт, “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

Хоёрдугаарх нь Монгол Улсын Засгийн газар БНКАУ-ын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүн байна уу? Жангабыл гишүүн байна. Жангабыл гишүүн.

Х.Жангабыл: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Горимын санал байна. Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Казакстан Улсын хоорондын Засгийн газар хоорондын тэтгэврийн талаарх хамтран ажиллах энэ хэлэлцээрийг эхний ээлжид хэлэлцэж өгнө үү гэсэн горимын саналтай байна аа.

Г.Тэмүүлэн: Жангабыл гишүүн горимын санал гаргалаа.

Хоёр дахь асуудлыг эхэнд хэлэлцэх горимын саналыг гаргаж байна. Гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг явуулъя. Өөр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Жангабыл гишүүний горимын саналаар санал хураалтыг явуулъя.

Хоёр дахь асуудал буюу Монгол Улсын Засгийн газар БНКАУ-ын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг

Соёрхон батлах тухай хуулийн төслийг эхэнд нь хэлэлцье гэсэн асуудлыг дэмжье гэдгээр горимын санал хураагдана.

Санал хураалтыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Санал хураалт 53.8 хувиар дэмжигдлээ.

Хэлэлцэх асуудалдаа орцгооё. Монгол Улсын Засгийн газар БНКУ-ын Засгийн газрын хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж эхэлье.

Ингээд хуулийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Лувсанцэрэнгийн Л.Энх-Амгалан сайд танилцуулна.

Л.Энх-Амгалан: Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Дэлхий нийтээр шилжин суурьшигч иргэд тэдний гэр бүлийн нийгмийн хамгааллын эрхийг хангах тухайн улсын иргэдийн адил харилцан эрх тэгш үүрэгтэй байх 2 улсын нийгмийн хамгааллын тогтолцоонд давхар хамрагдаж шимтгэл төлөхөөс зайлсхийх хамгийн үр дүнтэй арга хэрэгсэл бол нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээрийг байгуулан дээрх асуудлыг шийдвэрлэж байна аа.

Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газраас БНКАУ-тай тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах хэлэлцээр байгуулах хэлэлцээрийг 2018 оноос эхлүүлж улмаар Монгол Улсын Засгийн газар болон БНКАУ-ын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрт 2 тал 2024 оны 10 сарын 29-ний өдөр гарын үсэг зурсан. Энэхүү хэлэлцээр нь нийгмийн даатгалын хуульд зааснаас өөр журмаар тэтгэврийн эрх үүсгэх олгох харьцааг зохицуулсан тул олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-д зааснаар заавал соёрхон батлах олон улсын гэрээ юм аа.

Монгол Улсын Засгийн газар болон БНКАУ-ын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь нэг зүйлтэй ба Монгол Улсын Засгийн газар БНКАУ-ын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газарт өргөн мэдүүлснээр соёрхон батлуулахаар тусгасан болно. Гадаад харилцааны яамны мэдээллээр 2023 оны байдлаар БНКУ болон батлуулахад тусгасан болно ГХЯ-ны мэдээллээр 23 оны байдлаар БНКАУ-д Монгол Улсын 8036 иргэн оршин сууж байгаагаас 3115 иргэн албан ёсоор ажил хөдөлмөр эрхэлж байгаа бол ГИХГ-ын мэдээллээр Монгол Улсад БНКАУ-ын 564 иргэн оршин сууж байна аа. Уг хэлэлцээр хэрэгжсэнээр 2 улсын иргэд Монгол Улс болон БНКАУ-д ажилласан жил, шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн өндөр насны тэтгэвэр тогтоолгох Монгол Улсын иргэд БНКАУ-

аас хуримтлалын тэтгэврийг хийх тогтоолгон авах боломж бүрдсэнээр тухайн хүний ирээдүйн нийгмийн баталгаа сайжрах юм аа.

Иймд Монгол Улсын Засгийн газар болон БНКАУ-ын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулан хэлэлцүүлж байна аа. Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй бөгөөд улсын болон нийгмийн даатгалын төсөвт нэмэлт хөрөнгийн эх үүсвэр шаардагдахгүй болно. Хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж засгаар хэлэлцүүлсэн байгаа. Энэ засгаар хэлэлцүүлсэн хуулийн төслийг энэ хэлэлцээрийг Их Хурлаар болон Байнгын хороогоор соёрхон батлахыг дэмжиж өгнө үү.

Г.Тэмүүлэн: Баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад Засгийн газраас ажлын хэсгээс орж ирж байгаа бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал хуримтлалын сангийн бодлогын газрын дарга Рэнцэнханд, НДЕГ-ын дарга Батжаргал, мөн яамны Нийгмийн даатгал хуримтлалын сангийн бодлогын газрын Хуримтлалын нэгдсэн сангийн хэлтсийн дарга Хишигбаяр гэсэн бүрэлдэхүүнтэйгээр оролцож байна аа.

Хуулийн төслүүдтэй холбогдуулаад хууль санаачлагчаас асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. Алга байна. Хуулийн төслүүдтэй холбогдуулж үг хэлэх, санал хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Тэгвэл санал хураалтыг явуулна. Гишүүдэд зар дуулгаарай. Гишүүд хуралдаандаа орж ирцгээгээрэй за.

Монгол Улсын Засгийн газар, БНКАУ-ын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг батлахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалтыг явуулъя дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

61.5 хувиар дэмжигдлээ.

Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

Хоёр дахь асуудалдаа орцгооё.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулган дээр танилцуулах байгаа саналаараа танилцуулах хүсэлтэй гишүүн байна уу манай Байнгын хорооноос Жангабыл гишүүн үү? Тэгье Жангабыл гишүүн нэгдсэн чуулган танилцуулна.

13.50 цагт

Хоёр дахь асуудалдаа орцгооё. “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж эхэлье.

Холбогдох яамдын албан тушаалтнуудыг оруулахыг хүсье. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад Засгийн газраас орж ирсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Эдийн засаг хөгжлийн яам,

Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД Батхүү, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Эрдэнэбат, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын даргыг түр орлон гүйцэтгэгч Л.Энх-Амгалан, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төслийн бодлого зохицуулалтын газрын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Балчинлуvsан, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын салбар дундын зохицуулалт төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Мөнгөнсүх гэсэн байна.

Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Райымбек ирсэн байна. Эдийн засаг, хөгжлийн яамны салбар дундын зохицуулалт төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Отгонцэцэг,

Гадаад харилцааны яамнаас

Гадаад харилцаан яамны ТНБД Мөнхтүшиг, ГХЯ-ны бодлогын газрын дэд захирал Бямбадорж,

Батлан хамгаалах яамнаас

Батлан хамгаалах яамны ТНБД, Бригадын генерал Ганхуяг дарга байна. ОБЕГ-аас ОБЕГ-ын дарга хошууч генерал Ариунбуян, ОБЕГ-ын Санхүү, ар талын газрын дарга хурандаа Мөнхдорж гэсэн байна.

Цөмийн энергийн комиссоос Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга Манлайжав, Сангийн яамнаас Сангийн яамны ТНБД Ганбат, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт хөрөнгө оруулалтын газрын дарга Дэлгэржаргал байна. Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Тэлмүүн. Ийм бүрэлдэхүүнтэйгээр Засгийн газрын ажлын хэсэг орж ирсэн байна аа.

Ингээд Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуульд заасны дагуугаар бид нар хуулийн төслийг заалт тус бүрээр нь бол хэлэлцэхээр байгаа.

Заалт бүр тус бүрээр нь явна. 1 дүгээр асуудал

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 1 дүгээр заалттай холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Нийт үндсэндээ 4 заалттай тогтоол байгаа. Заалт тус бүрээр нь явна. Гишүүд холбогдох заалт болоод Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд холбогдох яамд, Тамгын газруудаас асуулт асуух эрх нээлттэй байгаа. Гишүүдийн нэрсийг авъя.

Нэгдүгээр заалттай холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Тогтоолын төслийг гишүүдэд тараасан байгаа байх. Цахим дээр байршуулсан байгаа байх тиймээ.

Нэгдүгээр заалттай холбоотойгоор нэрсийг Болормаа гишүүнээр тасалъя. Жангабыл гишүүн.

Х.Жангабыл: Ажлын хэсгийнхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Монгол Улсын Засгийн газрын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт ер нь 4 бодлогыг чиглэл болгон тусгачихсан байгаа. Бүсчилсэн хөгжлийн бодлого, хүний хөгжлийн бодлого, эдийн засгийн бодлого, хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого гээд. Энэ хүрээнд нэлээд реформ хийх, реформын чанартай нэлээд юм байна. Энд нэг асуулт байна аа. Эдийн засгийн эрх чөлөөний реформ гээд. Тэнд бол төрийн албаны шинэчлэлийг хийж чиг үүргийн давхардлыг арилгаж төрийн албан хаагчдын тоог багш, эмч нараас бусдыг нь 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ гэж заасан байна. Энэ 9 хувиар яаж бууруулах гэж байна? Энэ тал дээр хариулт авмаар байна.

Г.Тэмүүлэн: Жангабыл гишүүний асуултад хариулъя. 2 номер.

Ц.Эрдэнэбат: Эдийн засаг, хөгжлийн яам, Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газар Эрдэнэбат. Гишүүний асуултад хариулъя. Энэ 9 хувь гэдэг бол бид нарын урьдчилсан тооцоолол байгаа. Тэгээд түрүүний таны хэлснээр тэр төрийн чиг үүргийн цогц шинжилгээ хийх, процессын дахин инженерчлэл хийх болон энэ бусад ажлуудыг хийгдсэний үр дүнд яг аль албанаас хэдэн хувийг хэрхэн цомхотгох вэ гэдэг нь нэлээд гарч ирэх юм.

Мөн энэнтэй холбоотойгоор энэ яг зөвхөн яг энэ төрийн албан хаагчдынхаа тоог бууруулах гээд байгаа биш. Энэ нь болохоороо энэ реформын хүрээнд төрийн ялангуяа урсгал зардлыг ДНБ-д эзлэх 24 хувь хувиар бууруулах ер нь энэ төрийн үйлчилгээг иргэддээ хүргэх гэх мэт нэлээд олон энэ цогц ажлууд орсон хүрээнд байгаа. Тэгэхээр таны асуултад хариулахад 9 хувь бол урьдчилсан тооцоо, яг нарийвчилсан яг аль салбараас хаанаас хэдэн хувь цомхотгох юм тэр цомхотгосон хүмүүс нь буцаад түрүүний ярьснаар тэр төрийн чиг үүргийг хувьд байдаг юм уу, экспертүүдэд төрийн бус байгууллагуудад шилжүүлэх хүрээнд магадгүй зарим ажил нь тийшээ, зарим төрийн албан хаагчид тийшээ шилжих мөн тэр цомхотгогдох ажил төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг яах вэ гэх мэтчилний төлөвлөгөөнүүд нь энэ ондоо багтааж эцэслэгдэж гарсны дараа яг аль албанаас хэдэн хувиар бууруулах нарийн тооцоо гарна аа.

Г.Тэмүүлэн: Жангабыл гишүүн нэмж тодруулъя.

Х.Жангабыл: 9 хувиар бууруулах судалгаа хийсэн юм уу? Таны хариултыг ерөөсөө л ойлгохгүй байна.

Тодорхой юм хэлж өгөхгүй тойруулаад юм яриад байх юм. Судалгаа хийгээд энэ реформын чанартай юм хийнэ гээд энэ тодорхой биччихсэн байна шүү дээ 9 хувь гээд. Ер нь төрийн албаны тухай хууль төрийн алба гэдэг чинь их хэцүү болчихоод байна шүү дээ. Гишүүн бүгдийн ярьдаг сэдэв. Энд бичсэн мөртөө тунхаглалын чанартай яг хийх гэж байгаа юм нь тодорхойгүй. Тодорхой хариулт авмаар байна аа.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсэг гишүүний асуултад хариулъя. 2 номер.

Ц.Эрдэнэбат: Гишүүн ээ Эрдэнэбат Эдийн засаг, хөгжлийн яам. Яг 9 хувь гэдэг бол бид нар урьдчилсан судалгаа бол хийсэн 9 хувь нь ойролцоогоор 20421 болох юм байна лээ. Үүнийгээ үйлчилгээ, тусгай захиргаа, улс төрийн гээд задлаад тоонууд явж байгаа. Тэгэхдээ яг энэ тоогоо зарлахад арай эрт байгаа учраас би хараахан хэлж амжихгүй байгаад байна. Тэрнээс бид нарын урьдчилсан тооцоо хийсэн. Тэгэхдээ яг нарийвчилсан тоо нь болохоороо миний түрүүний хэлсэн төрийн чиг үүргийн шинжилгээ болон процессын дахин инженерчлэл болон бусад тооцооллуудыг хийж байж эцэслэн гарах юм.

Г.Тэмүүлэн: Жангабыл гишүүн болсон уу? Болормаа гишүүн байхгүй байна. Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэболд: Тэр процессын дахин инженерчлэл гэдгийг төрийн бодлогын үйл явцыг дахин загварчлах эд нар гээд Их Хурал дээр нэг тийм нэр томъёотой холбоотой ажлын хэсэг яваад байгаа юм байна лээ. Би тэнд саналаа хэлсэн. Тэгэхээр тэр Эрдэнэбат дарга аа яана биз дээ та хэд цаагуураа нэгтгэгдээд өөрөөр хэлбэл нэр томъёон дээр тодорхой саналууд өгсөн байгаа. Тэгэхээр нөгөө болж өгвөл энэ бусад Байнгын хорооны хэлэлцүүлэг эд нар дээрээ шуурхай энийг аваад тусгачихмаар байгаад байгаа юм.

Зүгээр энэний гол юм нь зүгээр өөлж шүүмжлээд байгаадаа биш. Ерөөсөө төрийн бодлогын энэ зорилтууд, иргэдэд аль болох ойлгомжтой энгийн хялбар хүрч байж л олон нийт, төрийн бодлогыг дэмжих тэр сэжим үүснэ л гэж үзээд байгаа юм л даа. Тэгэхээр аль болохлоор боломжит ингээд Монгол хэлээр ойлгомжтой илэрхийлэх зүйлүүдээ нэр томъёоны хувьд этимологийнх нь хувьд энэ дээр нь нэг тусгаж тавиагч гэсэн зүгээр техникийн санал байгаад байгаа юм.

Хоёрдугаарт нөгөө чуулган дээр хэлсэн. Дараа нь хоёулаа санал солилцсон байгаа шүү дээ. Нөгөө яг энэ 1 дүгээр хэсэг яригдахаар чинь нөгөө бүлэглэлд 4 бүлэг байгаа шүү дээ тиймээ. Энэ бүлгийн асуудлыг эргэн харах боломж байна уу? Одоо энэ чинь болохоороо бүсчилсэн хөгжлийн бодлого, хүний хөгжлийн бодлого, эдийн засгийн бодлого, хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого гээд байгаад байгаа шүү дээ. Энэ дээрээ бол яг миний тодорхой бүр яг зарчмын зөрүүтэй саналын түвшинд хэлэх гээд байгаа зүйл нь нэгд нь болохоор энэ хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого бол эрэмбийн нэгд байх ёстой гэж үзээд байгаа юм. Намар хэлээд бараагүй юм. Одоо бүр

ингээд бүр хариуцлагатайгаар хэлэхэд 2 дугаарт нь болохоор тэр хүний хөгжлийн бодлого тэгээд тэр бүсчилсэн хөгжил эдийн засгийн бодлого гэсэн дараал дараалсан дараатай авах боломж байна уу? Намрын энэ нөгөө 2025 оны төлөвлөгөөнөөс хойш 11 сарын сүүлээр Улсын Их Хурал хүнд төвтэй 5 тулгуурт стратегийн зорилт тавьчихсан байгаад байгаа. Энэ стратегийн 5 зорилгын хүрээнд яг энийгээ нэг ингээд шалгуур үзүүлэлт болгоод тэгээд энэ хөгжлийн бодлого чинь тэдэнтэйгээ уялдах ёстой болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхгүй болохоор тэнд нэг тунхаглалын чанартай цаас үлдчихдэг. Энд бид нар өөр юм ярьдаг болчих гээд байгаа юм. Ер нь явж явж бол нөгөө 2050 алсын хараа дунд, богино хугацааны бодлогууд болон сонгуулиар намуудыг нь тавиад мөрийн хөтөлбөр орчихсон байгаа. Нийтдээ 11 бодлогын бичиг баримт байгаа тийм үү.

11 бодлогын бичиг баримт дээр нэмэх нь энэ дотор чинь үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал орчихсон. Тэр дахиад шинэчлэгдэх түвшиндээ явж байгаа. Тэгэхээр ядаж энэ өнгөрсөн парламентаас гаргасан энэ 4 жилийн стратегитай нь уялдуулаад яагаад гэхээр энэ шийдвэр чинь өөрөө парламентаас гарах учраас энэ эрэмбэ байж болох уу? Энийг би асуумаар байгаад байгаа юм. Болбол сайн байна болохгүй бол тайлбар хэрэгтэй байгаад байна.

Г.Тэмүүлэн: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. 2 номер.

Ц.Эрдэнэбат: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Эрдэнэбат, Эдийн засаг, хөгжлийн яам. Бид нар нөгөө Засгийн газар төслөө өргөн барьчихсан. Тэгэхээр одоо нөгөө гишүүд Улсын Их Хурлын гишүүд бүрэн эрхийнхээ хүрээнд Байнгын хороо болон ажлын хэсэг дээр санал гаргаад энэ нэр томъёо болон энэ өөрчлөлтийг санал гаргах боломжтой байх. Тэрнээс бид нар өргөн барьчихсаны дараа бол бид нар энийгээ өөрчлөх боломжгүй болчихож байгаа юм.

Г.Тэмүүлэн: Эрдэнэболд гишүүн нэмж тодруулъя.

С.Эрдэнэболд: Тэгэхээр Байнгын хорооны даргад санал тавих гээд байгаа юм. Энэ нь болохоор зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор энэ дээр бас энэ эрэмбийг яг энэ оруулж ирж байгаа саналаас нь өөрчилмөөр байгаа. Энийг чуулган дээр Эдийн засгийн хөгжлийн сайдаас тодруулга авсан. Их Хурлынхаа түвшинд та нар ингэх боломжтой гэсэн байр сууриа илэрхийлсэн. Тэр ер нь яагаад вэ гэхлээр бид нар нөгөө нэг ингээд гол юмаа прайвити буюу нөгөө эрэмбээ аягүй зөв тогтох ёстой л гэж үзээд байгаа юм л даа. Яагаад гэхээр энэ хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого гэдэг дотор чинь нөгөө авлигагүй байх, авлигын эсрэг байх гээд өөрөөр хэлбэл бид нар нэг эдийн засгийн хөгжлийг нэг том сав тогоо гэж үзэх юм бол цоорхойгоо нөхөх тухай ойлголт байхгүй юу. Алдаа засвар тэр цоорхойгоо нөхөхгүй байгаад мянган хөрөнгө оруулалт мега төсөл явуулаад тэр цоорхойгоор нь гоожоод л байна. Одоо байгаа энэ нэг цоорхой гээд байгаа энэ хүний хөгжил авлигын индекстэй холбоотой яг энэ хүний эрхийн хөсөрдүүлээд байгаа хүний эрхийн мэдрэмжгүй шийдэл гаргаад байгаа тэр зүйлүүдээ бид нар энэ засаглалын бодлогоороо нэгд оруулаад 2-т, 3-д, 4-д гэсэн түрүүний хэлсэн саналаар энэ зарчмын зөрүүтэй санал.

Г.Тэмүүлэн: Эрдэнэболд гишүүн санал гаргаж байна. Асуулт асууя Болормаа гишүүн.

Э.Болормаа: Миний зүгээс 2 асуулт асууя.

Эхнийх нь бол Гадаад хэргийн яаманд ирэх жил Коп-17 зохион байгуулах ажил нь 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд огт тусгагдаагүй харагдаж байна. Бидний хувьд бас нэлээн том арга хэмжээг олон улсын арга хэмжээг Монгол Улсдаа зохион байгуулахаас гадна цөлжилтийн эсрэг ийм том зорилтот үйл ажиллагаа гэж харж байна аа.

Тэгэхээр энэ яагаад ороогүй юм бэ? Энэ 2026 оны төлөвлөгөө биш юм уу? 2026 онд хийх нь хойшлогдсон юм уу гэдэг ийм асуулт асууя.

Хоёр дахь нь бол Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөр гэж би нөгөө зурагдсан пянз шиг л хэдэн дунд хугацааны хөтөлбөрүүдийг яриад байна л даа. Манай энэ Байнгын хороотой холбоотой маш тодорхой 8 дунд хугацааны хөтөлбөрийн нэг нь бол энэ үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөр байгаа. Энэ дээр ажлын хэсгийг хаанаас ахалж байгуулах вэ? Та бүхэн энэ харьяа байгууллагууд ер нь Байнгын хороонд харьяалагдах энэ байгууллагууд энэ дээрээ ямар нэгэн одоогийн байдлаар бодлого гаргасан байгаа юу? Үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ гэдгийг яаж харж байгаа вэ?

Г.Тэмүүлэн: Болормаа гишүүний асуултад хариулъя. 3 номер Батхүү дарга.

Б.Батхүү: Болормаа гишүүний асуултад хариулъя аа.

Энэ 3.11.2.3 дээр Цөлжилттэй тэмцэх НҮБ-ын суурь конвенцын талуудын 17 дугаар бага хурлыг зохион байгуулах гээд тусгачихсан байгаа. Танд өгөгдсөн материал дээр. Өрсөлдөх чадварыг гэж эхэлж байна.

Г.Тэмүүлэн: Болормаа гишүүн болчихлоо гэж үзэх үү тэ? Тэгэхдээ Үндэсний өрсөлдөх чадварын зорилт 2 дахь асуулт дээр хэн хариулах вэ? 2 номер Эдийн засгийн хөгжлийн яам.

Ц.Эрдэнэбат: Болормаа гишүүний асуултад хариулъя. Эдийн засгийн хөгжлийн яам Эрдэнэбат.

Үндэсний бид нар зорилтот хөтөлбөрүүдээ хийхээр бэлдэж байгаа. Тэгээд яг үндэсний өрсөлдөх чадварыг ажлын хэсгийг хэн ахлах вэ гэдгийг бид нар засгийн түвшинд ярьж байгаад яг одоогоор бол яг тэр ахална гэсэн шийдэл байхгүй байгаа. Хэрэв танд санал байвал бид хүлээж авахад бэлэн байна.

Г.Тэмүүлэн: Эдийн засаг, хөгжлийн асуултад нэмээд хариулаарай. Болормаа гишүүн тодорхой асуулт асууж байна. 2 номер хариулах уу? 2 номер.

Ц.Эрдэнэбат: Эрдэнэбат яг сөрөн тэсвэрлэх гэсэн ажлын хэсэг БХЯ-ан дээр ажиллаад явж байгаа. Бямбацогт сайдаар ахлуулсан ажлын хэсэг ажиллаад явж байгаа.

Г.Тэмүүлэн: Болормаа гишүүн болсон уу? Анар гишүүн асуулт асууя.

Ч.Анар: Өдрийн мэнд. Кибер аюулгүй байдал ноцтой болоод байгааг бид нар бүгдээрээ харж байгаа. Тэгээд энэ маш олон халдлагууд маш их нэмэгдээд л байгаа. Тэгээд энэ кибер аюулгүй байдалд энэ хөгжлийн төлөвлөгөөний хөтөлбөр 4.5.4 дээр кибер аюулгүй байдлын үндэсний стратеги хэрэгжүүлнэ гэж орсон байгаа. Тэгээд л үндсэн хариуцагч нь Цахим яам гэж байх юм. Энэ чинь ганц цахим яамны ажил биш шүү дээ. Энэ чинь Кибер аюулгүй байдлын тухай хуулиараа Кибер аюулгүй байдлын зөвлөл гэж Ерөнхий сайдын доор байгаа. Үүн дээр БХЯ-ны харьяа байгууллага, ТЕГ-ын харьяа байгууллага, Цахим яамны харьяа байх ёстой. Гэтэл ганцхан цахим яаман дээр үндсэн хариуцагчаар нь нийт төсөвт өртөг 38.8 тэрбум гээд төсөв тавьчихсан байх юм.

Тэгээд энэ БХЯ-ан дээр байгаа юу? Энэ арми сертийн асуудлын төсөв хүндэрчихсэн байгаа. Ноднин бол яриад ороогүй. Тэгээд энэ яагаад орж ирэхгүй байгаа юм бэ?

Хоёрдугаарт яах вэ тусгай чиг үүргээрээ Тусгай хяналтын дэд хороогоороо Нат серт буюу тагнуулын төсөв орсон байгаа байх. Энэ батлан хамгаалахын кибер аюулгүй байдлын төсвийг яагаад тусгаагүй байгаа юм бэ? Энэ бас яагаад цахим яам байгаа юм бэ гэдэг 1 дүгээр асуулт тавимаар байна.

Хоёрдугаарт яг энэнтэйгээ уялдаад үндэсний кибер халдлагаас хамгаалах үндэсний төлөвлөгөөг Засгийн газар батална гэсэн түрүүний хурал дээр асуугаад гаргаж өгөөгүй боловсруулж байгаа гэсэн. Энэ хаана боловсрогдож байгаа вэ хэзээ гарах вэ? Тэгэхгүй бол одоо бид нар Монгол Улсын мэдээллийн аюулгүй байдал улам бүүр алдагдаж байна.

Хоёрдугаарт нь тодруулга асуух гэсэн юм. Энэ Хууль зүйн яаман дээр дроны үйлдвэрлэл барих төсөв тавигдсан байгаа. БХЯ-ан дээр дроны үйлдвэрлэл баригдах төсөв тавигдсан байна. Энэ 2 үйлдвэр маань хоорондоо уялдаатай ажиллаж байгаа юу? Монгол Улсад өөрөө боловсон хүчин болоод технологийн бүтээмж маш багатай. Тэгэхээр хоорондоо уялдаатай ажиллаж байгаа юу. Эсвэл тус тусдаа үйлдвэрүүд хийх гээд төлөвлөчихсөн байгаа юу? Нэг нь Хууль зүйн яамны доор. Нэг нь Батлан хамгаалахын яаман дээр.

3 дахь асуулт. Үндэсний аудитаас энэ төрийн аудитын байгууллагын цахим шилжилтийг 4 тэрбум төгрөгөөр гадаадын тусламжаар хийнэ гэж байна. Гэтэл энэ төрийн аудитын байгууллагын мэдээллийн сан бичиг баримт чинь бол Монгол Улсын төрийн бүх байгууллагуудыг үйл ажиллагаа, санхүү, төсөв тооцоотой холбоотой нэн нууцлалтай мэдээлэл. Гэтэл энийг яагаад гадаадын тусламжаар хийнэ гэж байгаа юм бол. Гадаадын тусламж гэдэг нь гаднын санхүүжилттэй хийх гэж байгаа юм уу эсвэл гаднын систем авчирч тавих гэж байгаа юм уу. Тэгээд энэ нөгөө аюулгүй байдал нь Монгол Улсын хамгийн эмзэг мэдээлэл бүхий өндөр нууцлалтай мэдээллийг яагаад дотоодын биш гаднын

тусламжаар тэгээд хийх гэж байгаа нь энэ ямар учиртай юм бол? Энэ 3 асуултад хариулт авъя.

Г.Тэмүүлэн: Ажлын хэсгээс Анар гишүүний асуултад хариулъя. Ганхуяг даргаар болох уу? 2 номер.

Д.Ганхуяг: БХЯ-ны ТНБД Ганхуяг. Энэ манай кибер командлалтай холбоотой зардлын асуудал бол цахим яаман дээр санал нь энэ дээр орчихсон явж байгаа. Яг манай дээр л салж тусаагүй байгаа. Дроны үйлдвэрийн талаар 2025 оны төсөв дээр суусан зардлаараа бид дрон үйлдвэрлэх ажлыг эхлүүлээд явж байгаа төслийг нь бол хийж байгаа. Мөн одоо гаднын зээл тусламжаар асуудал яригдаж байгаа. Тэрийг бол танд тусад нь хүргүүлье.

Г.Тэмүүлэн: 3 их тодорхой асуулт л асуусан даа. Өөр нэмж хариулах хүн байна уу? Ажлын хэсгээс. Саяын санхүүжилт, тусламжаар яагаад хийгдэж байгаа эд нар гээд асуудлууд байсан. Хэн хариулах вэ? Гараа өргөөрэй ажлын хэсэг. 2 номер Эдийн засаг, хөгжлийн яам.

Ц.Эрдэнэбат: Анар гишүүний асуултад хариулъя.

Эрдэнэбат Эдийн засаг, хөгжлийн яам. Саяын тэр юун дээр бол ер нь нөгөө улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулахад бид нарт нэг баримжаагаар нэг 900 орчим төсөл арга хэмжээний санал ирсэн. Тэгээд энэ хуулийн шалгуур заалтуудаар үндэслэлээрээ зарим нь хасагдаад ирүүлсэн яамдуудын саналыг нь үндэслээд зарим нь үндсэн эсвэл зарим төсөл арга хэмжээг нэгтгэх байдлаар ингээд явж байгаа. Саяын кибер аюулгүй байдал дээр бол яг одоогийн хөгжлийн бодлого дээр жилийн төлөвлөгөө дээр цахим яам үндсэндээ хариуцахаар ингээд явж байгаа. Дроны үйлдвэрлэл бол миний ойлгосноор 2 тусдаа ажил яригдаж байгаа. Энэ 2 тусдаа үйлдвэр юм гэж ойлгосон.

Тийм учраас 2 тусдаа заалт ороод явж байгаа.

Г.Тэмүүлэн: Анар гишүүн та нэмж тодруулъя.

Ч.Анар: Харин тэр нөгөө төсөв нь яагаад зөвхөн цахим яаман дээр оччихсон юм бэ гээд асуухаар эргээд хариулаад байх юм. Тэрийг л хариултыг нь гээд байгаа юм. Энэ Батлан хамгаалахын кибер командлал л дээр яагаад төсөв тавигдахгүй байгаа юм бэ? Яагаад ганцхан цахим яам хариуцагчаар тавьчихаад байгаа юм. Энэ чинь ерөнхий хариуцагч нь Кибер аюулгүй байдлын зөвлөл шүү дээ.

Тэгэхээр энэ төсвийг одоо БХЯ-аар кибер командлал руу хуваарилах асуудлыг нь яаж процессын хувьд цахим яам руу хийчихээр яаж хийх юм бэ? Энэнийхээ хариултыг ерөөсөө авсангүй.

Хоёрдугаарт тусдаа төсөл явж байгааг нь мэдэж байгаа. Гэхдээ давхардсан хөрөнгө оруулалт хийхгүй, боловсон хүчний дутагдлын улмаас энэ энэ хоорондынхоо уялдааг хангах ажил, хамтарсан ажлын хэсэг гарсан уу гээд

асуугаад тэрнээс тусдаа байгааг нь би хараад уншаад л байна л даа. Үндэсний аудит байхгүй. Тэрийг нь хариултаа авч чадахгүй нь.

Г.Тэмүүлэн: Анар гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? 2 номер Эдийн засаг, хөгжлийн яам.

Ц.Эрдэнэбат: Бид жилийн төлөвлөгөөн дээр ирсэн саналаа ингээд дуусчихсан байгаа. Тэгэхээр бид нар буцаад яг засаг дотор БХЯ болон нөгөө ирүүлсэн саналуудтай ахиж бид ярилцаад танд саналаа буцаагаад хүргүүлье ээ.

Уялдааг хангах тал дээр таны энэ саналыг бид тэр төсөл хэрэгжүүлэх түвшинд нь анхаараад ажиллая.

Г.Тэмүүлэн: Батсүмбэрэл гишүүн асуулт асууя. Батсүмбэрэл гишүүн.

Н.Батсүмбэрэл: Энэ ОБЕГ, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яамнаас. Ер нь жил болгон энэ гарч байгаа осол аваар, гамшиг аврах ажиллагааны тоо нэмэгдэж байгаа мэдээлэл байдаг. Үүнд шаардлагатай хөрөнгийн зардал нэмэх шаардлага гардаг.

Дээрээс нь алба хаагчдын дунд болон нийтийн дунд энэ онцгой байдлын алба хаагчдын техник хэрэгсэл, ажиллах орчныг сайжруулах, хувцас хэрэглэлийн чадавхыг нэмэгдүүлэх асуудлууд байнга яригддаг. Энэ чиглэл дээр 2026 оны төсөвт ямаршуу төсөв та нар төсөөлж байна? Сангийн яам төсөөлж байгаа мөнгө юу байна? Тоо нэмэгдэж байгаа юу эс үгүй бол хэвэндээ байж байгаа юу? Арай буураагүй байлгүй дээ. Энэ дээр Сангийн яам нэг тодорхой тоон дээр нэг хэлмээр байна. Эдийн засаг, хөгжлийн яам энэ чиглэл дээр ер нь ямар бодлого барих юм. Ер нь энэ гамшгийн асуудал дээр, аврах эрэн хайх ажиллагааг явуулах асуудал дээр энэ тэргүүлэх чиглэлийн арга ажиллагааг хэрхэн нэвтрүүлэх, энэ одоо байгаа хүчээ яаж нэмэгдүүлэх, ялангуяа алба хаагчдын тоног хэрэгсэл техник хангамжийг нэмэгдүүлэх дээр ямар бодлого эдийн засгийн яам гаргаж байгаа юм.

ОБЕГ энэ дээр та бүхэн бодитойгоор 2025 онд юу хийчихсэн юм. 2026 онд юу хийх гэж байгаа юм. Энэ дээрээ нэг бодитой тоо байна уу? Улаанбаатар хотын хувьд л аваад үзэхэд шинээр анги байгуулсан уу? Миний хувьд дүүргийн Засаг даргаар ажиллаж байхад дүүргийн төсвийн хөрөнгөөр энэ Мөнгөнсүх энд сууж байна. Дүүргийн төсвийн хөрөнгөөр бид нар 5 тэрбум төгрөг гаргаад дүүргээрээ онцгой байдлын анги барьж өгсөн. Энэ онд ашиглалтад орно. Улс маань анги барьж өгч байгаа юу? Улаанбаатар хотод хүн нэмэгдээд байдаг. Тэгээд яваад очдог, нөгөө орц гарц нь чөлөөлөгдөж байгаа юу?

Гал руу яваад ордог алба хаагч нарын тоног хэрэгсэл хүүхдийн тоглоом шиг хэвээрээ байгаа юу? Сайжирч байгаа юу? Хүнд хэрэглэгдэх нэгж хангамжууд яаж нэмэгдэх вэ? Энэ дээр та бүхэн нэг тодорхой тоотой баримттай нэг хэлээч. Сангийн яам тэр дээр тодорхой тоогоо хэл. Эдийн засаг, хөгжлийн яам энэ дээр тодорхой зорилтоо хэл. Ямар зорилт гараад яваад байгаа юм.

ОБЕГ-ын бодитой баримт хэл. Тэгээд та бүхэн энэ хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд 2025, 2026 онд нэгж албан хаагчид ноогдох тоног төхөөрөмж, техник хангамж яаж сайжирч байгаа юм. Та бүхэнд хүнд ноогдох тойрон хамран аврах эрэн хайх ажиллагаа яаж сайжрах юм. Энэ дээр яг бодитой юм та нарт ноогдож байгаа юм уу. Байхгүй бол байхгүйгээ хэл? Байгаа юм бол байгаа гэдгээ хэл. Одоо тэгээд тэр чинь гал жилийн 4 улиралд гарна, үер гарна, зуд гарна, усанд болон бусад чиглэлээр эрэн хайх аврах ажиллагаа хийгдэнэ. Тэгээд энэ чиглэл дээр тодорхой нэг хариу өгөөч.

Г.Тэмүүлэн: Холбогдох албан тушаалтнууд асуултад хариулъя. Батсүмбэрэл гишүүнийх. Эхлээд 3 номер Эдийн засгийн хөгжлийн яам. Дараа нь Сангийн яам, тэгээд ОБЕГ. 3 номер.

И.Батхүү: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн ТНБД Батхүү. Эдийн засаг, хөгжлийн яамны зүгээс энэ байгалийн гамшгийн холбогдолтой эрсдэлтэй хүчин зүйлсийг байнга анхаарч эдийн засгийн нөхцөл байдал цаашдын чиг хандлагад анхаарч ажиллаж байгаа. Энэтэй холбоотой эрсдэлийн шинжилгээндээ авч үзэж байгаа. Яг 2026 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний хувьд бол 3.17 дугаар бүлгийн 1.1, 1.2, 1.3 гэсэн заалтууд дээр 3 тодорхой арга хэмжээний саналыг тусгасан байгаа.

1.1.дээр бол дэвшилтэт технологи инновацад суурилсан гамшгаас хамгаалах, эрт сэрэмжлүүлэх, зарлан мэдээллийн нэгдсэн систем байгуулах гэдэг ажлыг.

1.2.дээр нь шаардлагатай дүүрэг, сумдад анги салбар шинээр байгуулах гэсэн ажлыг.

1.3.дээр онцгой байдлын техник тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх гээд саяын дурдагдсан асуудлуудыг шийдвэрлэх тодорхой заалтуудыг тусгасан байгаа. Ер нь өнгөрсөн хугацаанд гадаад зээл тусламжийн бодлогын хүрээнд онцгой байдлын салбарын аврах чадавхыг бэхжүүлэх, хүчин чадал, тоног төхөөрөмжийг сайжруулах чиглэлээр том том төслүүд хэрэгжүүлээд тодорхой үр дүн гаргаж ажилласан гэж ойлгож байгаа. Цаашдаа энэ бодлогын арга хэмжээг үргэлжлүүлж ажиллана аа.

Г.Тэмүүлэн: Сангийн яам 2 номер.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя аа. Ер нь бол онцгой байдлын байгууллагын хувьд бол сүүлийн 4 жилд төсөв нь 4 дахин өссөн байгаа. Гэхдээ бол төсвийн бүтцийг нь харах юм бол энэ төсөв маань нийтдээ бараг 60 орчим хувь нь цалин хөлс. Дахиад арваад хувь нь бол байр ашиглалт болон шатахуун гэх мэт зардлууд болчихоод байгаа юм.

Тэгэхээр өөрөөр хэлбэл бусад тэр аврах үйл ажиллагааны зардлууд тодорхой хэмжээнд хангалттай хүрэхгүй байна гэдэг нь харагдаад байгаа юм. Тэгэхээр онцгой байдлын байгууллагын хувьд тэргүүн ээлжид цалин хөлсийг буюу аврагчдын цалин хөлсийг бусад тэр байгууллагуудтай дүйцүүлэх хэмжээнд

ингээд ажиллаад болчихсон байна гэж бол төсвийн хувьд тоон мэдээн дээрээс харж байна аа. Нөгөөтээгүүр таны асуусан 2026 оны төсөв дээр ямар байдлаар явах юм бэ гэдэг дээр бол яг энэ цаг үед энэ жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй хамт төсвийн хүрээний мэдэгдэл явж байгаа.

Төсвийн хүрээний мэдэгдэл дээр бид нар нийт зарлагын хэмжээгээ бол оруулж ирнэ.

Г.Тэмүүлэн: Сангийн яам нэмээд хариулъя. 2 номер.

М.Санжаадорж: Тэгэхээр энэ төсөв маань батлагдсаны дараа бол хуулиараа бол Сангийн яам бол энэ бодлогын яамнаас орж ирсэн тоон дээр задлаад хязгаарын саналыг оруулж ирнэ. Хязгаар дээр бол хязгаар болон ирэх жилийн төсөв маань жилийн жилийн төлөвлөгөөгөө биелүүлэхэд чиглэсэн байх ёстой гэдэг хуулийн заалттай.

Одоогоор бид нар энэ жилийн хөгжлийн төлөвлөгөө дээр мэдэж байгаа зүйлүүд гэх юм бол онцгой байдалтай холбоотойгоор 3, 4 төслийн асуудлууд орж ирэх юм байна. Дээр нь бол нэмээд орон тоо бууруулах асуудал орж ирэх юм байна гэсэн ийм ойлголттой байна.

Тэгэхээр энэ хүрээндээ бол төсвийн хязгаарын саналыг өгнө. Ирэх жилийн төсвийн төслийг энэ хүрээндээ бид нар өгнө гэсэн ийм байдалтай байна аа.

Г.Тэмүүлэн: 4 номер Ариунбуян дарга.

Г.Ариунбуян: ОБЕГ-ын дарга хошууч генерал Ариунбуян илтгэж байна аа. Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Онцгой байдлын байгууллагын хувьд өнөөдөр техник, тоног төхөөрөмж, хувцас, тусгай зориулалтын хувцас хэрэглэлийн хангалт дунджаар 50 орчим хувьтай байгаа. Гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээний хувьд 45 орчим хувьтай.

Тэгээд ер нь сүүлийн жил талуудад Монгол Улсын төр засгаас Сангийн яамнаас эдийн засгийн хөгжлийн бодлого хариуцсан салбарын яамдуудаас манай төсөв санхүүжилтийг нэмэгдүүлэх тал дээр их анхаарал хандуулж байгаа. Тэгэхдээ бид нарт хэрэгцээ шаардлага бий. Ер нь бид нарын гаргасан судалгаагаар 100 хувь хангахад 800 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай байгаа. 2026 оны энэ жилийн төлөвлөгөөнд бид нар 150 орчим тэрбум төгрөг буюу одоо байгаа энэ 50 хувийг 18-аас 20 хувь нэмэгдүүлэх хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг тусгаж өгөөч гээд.

Г.Тэмүүлэн: 4 номер саналыг тавьсан.

Н.Ариунбуян: Тэгээд энэ хэмжээнд буюу өнөөдрийн байдлаар энэ төлөвлөгөөний төсөл дээр 15 орчим тэрбум төгрөгийн доод түвшин. Энэнээс дээшээ байж болно гэж ойлгож байгаа. Ийм төсөв тавигдахаар байгаа. Ер нь бол ойрын жилүүдэд энэ гамшгаас хамгаалах үйлчилгээ стандартын дагуу хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр гал унтраах анги нийслэлд 15-ыг, хөдөө орон

нутагт бол 27 эрэн хайх аврах бүлгийг байгуулахаар бид нар үе шаттай арга хэмжээ авахаар төлөвлөөд ажиллаж байна аа.

Г.Тэмүүлэн: Батсүмбэрэл гишүүн нэмж тодруулъя.

Н.Батсүмбэрэл: Ер нь энэ онцгой байдлын байгууллагын тоног хэрэгслийг, тусгай хэрэгслийг, энэ хангамжийг нэмэгдүүлмээр байгаа юм. Тэгээд энэ дээр сая Ариунбуян даргын хэлж байгаагаар хангалтгүй байгаад байгаа юм байна. Энийг нэмэгдүүлэх саналыг гаргаж байна. Тэгээд энэ дээр Эдийн засгийн яам Сангийн яам тооцоо гаргаад өгөх хэрэгтэй байна. Тэр Фукуок явж зугаалдаг сайд нарын мөнгийг тансаглалын мөнгийг энэ онцгой байдлын албан хаагч нарын хангамжид өг л дөө. Тэд нар Фукоукийн эрэг дээр зугаалж болдог онцгой байдлын албан хаагч нар шалдан нүцгэн гал руу ордог, өвлийн хүйтэнд цас зудтай зууралддаг байж таарахгүй биз дээ.

Г.Тэмүүлэн: Санал гэж ойлголоо. Нэмээд тодруулчихъя. Ариунбуян дарга 4 номер.

Г.Ариунбуян: Ер нь бол одоо ой хээрийн түймэр, объектын түймэр, ган, зуд, үер ус, тэгээд л цацраг, хими бүх л төрлийн гамшиг ослын дуудлагаар манай албан хаагчид үүрэг гүйцэтгэдэг. Жилийн 4 улиралд ер нь цаг чөлөө завгүй л ажиллаж байгаа. Тэгээд хамгийн түрүүн анхаарах юм бол албан хаагчдын хувцас хэрэглэл, техник тоног төхөөрөмжийн хангамж. Ер нь сүүлийн үеийн дэвшилтэт техник технологи, дрон, нисгэгчгүй нисэх төхөөрөмж, гал унтраах робот гээд бас өндөр хүчин чадалтай бөгөөд нөгөө талдаа бас ихээхэн үнэ өртөг шингэсэн ийм техникүүд байдаг. Тэгээд энэ хэмжээгээр бас нөгөө төсөв санхүүжилтийн хэмжээ нь өсөөд байгаа юм. Өсөөд байдаг.

Хоёрдугаарт нь гал унтраах анги шинэ салбар бүлгийг бид нар үе шаттайгаар байгуулж байна. Улсын хэмжээнд стандартаар 169 гал унтраах анги байхад өнөөдөр бол 77 гал унтраах анги үүрэг гүйцэтгэж байгаа. 330 сумын 220 суманд нь манай онцгой байдлын салбар нэгж байхгүй. Тиймээс одоо ингээд хүндрэл үүсдэг. Гамшиг ослын үйлчилгээг үзүүлсэнгүй гэж иргэдээс гомдол ирдэг. Үүний дагуу аймаг, орон нутгийн удирдлага, нийслэлээс ч гэсэн шинээр гал унтраах, эрэн хайх, аврах бүлгийг зайлшгүй байгуулаач гэдэг ийм хүсэлтийн дагуу бид нар ингээд байгуулахаар ажиллаж байгаа. Энэ хэмжээгээр л нөгөө урсгал зардал нь нэмэгдээд явж байгаа ийм зүйл бий.

Г.Тэмүүлэн: Батсүмбэрэл гишүүн нэмж үг хэлье.

Н.Батсүмбэрэл: Тэгэхээр энэ онцгой байдлын байгууллагын техник тоног төхөөрөмж, тусгай зориулалтын багаж хэрэгсэл, хувцас хэрэглэл, хангалтын санхүүжилтийг хөгжлийн төлөвлөгөөнд нэмэгдүүлэх саналтай байгаа юм аа. Саяхан гарсан тэр Жаргалантын сумын галыг та нар санаж байгаа. Өнгөрсөн жил гарсан тэр газны дэлбэрэлтийг санаж байгаа Улаанбаатар хотод. Тэр зурагтын миний дэлгүүрийн галыг санаж байгаа. Тэр хүүхэд усанд гүйгээд ээжтэйгээ явдгийг та бүхэн санаж байгаа. Өвөл машин тэргэндээ осгож хөлдөж нас бардгийг санаж байгаа. Тэгэхээр энэ бүхнийг бид нар хүртээмжийг нэмэгдүүлэх ёстой. Сая генералын үгэнд гарлаа шүү дээ. 169 анги байгаагаас

77 нь ердөө ажиллаж байна. Хүн байхгүй байна. Тээврийн хэрэгсэл байхгүй байна.

Тэгээд ичгүүртэй бүтэн улс байж бид нар гадаадын улсуудаас зээл тусламж, тоног төхөөрөмж яриад суугаад байгаа юм. Энэ өөр зардлаасаа Сангийн яам гаргаад энэ хөгжлийн төлөвлөгөөн дээрээ энэ санхүүжилтээ нэмэгдүүлэх саналыг гаргаад оруулаад бүүр бие даасан заалт болгоод оруулаад ир ээ. Ингэж байж хэдүүлээ цаашаа явна. Энэ чинь иргэдийн амь насыг, эд хөрөнгийг, улс орны бүрэн бүтэн байдлыг авран хамгаалах тухай асуудал ярьж байгаа юм. Тэрнээс биш хэдэн нөхдүүдийг Фукуок арал дээр аваачиж зугаалуулах гэхгүй.

Тийм учраас энэ асуудлыг бол онцгойлон Сангийн яаманд, Эдийн засгийн яаманд хэлье. Энэ мэргэжлийн чиглэлийн байгууллага бол бодит байдлаа л хэлж байна шүү дээ. 169 анги Монгол Улсад үйл ажиллагаа явуулах бололцоо байна харамсалтай нь 77 явж байна. Тэгээд бид нар хэзээ хэнийхээ амь насыг, эд хөрөнгийг аврах гээд байгаа юм. Энд сууж байгаа хүмүүсийн гэр оронд ч ах дүү нарт ч юу гарах юм. Тэгэхээр энэ бүхнийг та бүхэн одоогоос бодож энэ дээр хөрөнгө мөнгө тавьцгаа дарга нар аа. Энэ дээр анхаарцгаа гэдгийг би дүүргийн онцгой байдалд удирдаж ажилласан хүнийхээ хувьд цагийн хувьд хэтэрч байсан юмнуудыг би хэлье ээ.

Г.Тэмүүлэн: Ойлголоо. Баярлалаа. Батсүмбэрэл гишүүн үг, санал хэллээ. Өөр гишүүн үг байхгүй байх тиймээ.

Гадаад яамнаас нэг зүйлийг тодруулаадахъя.

Хийж хэрэгжүүлэх гэж байгаа арга хэмжээ төсөл хөтөлбөрүүдтэй холбоотойгоор төсвийн хүрээний мэдэгдэл дээр танай яамтай холбоотой 2 асуудал байгаад байгаа юм. Тэгээд энэ 2 асуудлаас өөр бусдаар ер нь ажил алба ер нь болно гэж үзэж байгаа юу? Бид нар манай Байнгын хорооны гишүүд Гадаад яаман дээр төсөв батлагдсаны дараа 12 сард очиж ажилласан. Тэгээд нэг хэд хэдэн асуудлаар чиглэл болгосон. Энэ дээр нэг онцлох зүйл нь бол яах вэ одоо нөхцөл байдал өөрөө та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа. Бид нар бүгдээрээ л ойлгож байна. Олон улсын нөхцөл байдал өөрөө тааварлашгүй ээдрээтэй нөхцөл байдалд орж байна. Тэгээд ийм юу гэдэг юм нэг талдаа ийм супер прагматик ийм бодлого угаасаа ноёлж эхэллээ. Илүү юу гэдэг юм бодит харилцааны цаг үе эхэлж байна л даа. Тэгээд бид нар энэ дээр хэлсэн зүйл нь Гадаад яам буюу бид нар энэ үндэсний эрх ашгийн хүрээнд 1 дүгээрт байгаа асуудал дээр гадаад бодлого дээр ямар нэг алдаа гаргах эрх байхгүй байгаад байгаа юм.

Тэгээд сүүлд Байнгын хорооноос бол бид нар очихдоо ирэх оны төсөв дээр та бүхэн төсвийн хүрээний мэдэгдэл дээр гол анхаарах юм бол энэ ерөөсөө дипломат албаа бэхжүүлэх тал дээр анхаараач ээ. Бодлогын судалгааны хүрээлэнг гадаад яаманд иргэдээ байгуулаач. Ахмад дипломатчдынхаа үгийг сонсдог болооч ээ, мэргэжлийн бодлого, судалгаан дээр суурилсан дүн шинжилгээ хийсэн ийм судалгаанд суурилсан бодлогыг гаргадаг байгаач гэсэн асуудлыг хөндөж тавиад байсан. Тэгэхээр бол нэг талдаа өөрөө гадаад яам,

бодлого шийдвэр гаргалт дээрээ энэ институцчилагдсан тогтолцоо буюу шийдвэр гаргалтын зөв механизмыг бол бүрдүүлэх хэрэгтэй байна. Судалгааны механизм хэрэгтэй байна гэдэг асуу бодол ярьсан. Энэ асуудлаа та хэд маань яг энэ төсвийн хүрээний мэдэгдлийн хүрээнд тодорхой шинээр төсөл арга хэмжээ оруулах шаардлага байсан уу үгүй юу?

Энэ ажил ер нь яг ямар түвшинд явж байна? Тооцоо судалгааг нь хийгээд Байнгын хороонд эргэж мэдэгдээрэй гэдэг асуудлыг тавьсан.

Хоёр дахь асуудал нь энэ ч яах вэ яг төсвийн хүрээтэй шууд хамааралтай асуудал бол биш. Нэг дэх нь яах вэ зүгээр энэ яг манай эрхлэх асуудлын хүрээнд бид нар энэ дипломат алба өөрөө хариуцлагатай алба аа. Тэгэхээр ямар нэг байдлаар бид нар энэ дипломат албыг бол амралт болоод зугаалгын газар байгууллага ол болгож болохгүй гээд байгаа юм. Тэгээд мэргэжлийн байх шаардлага хангасан хүмүүс байх. Өнөөдөр үндсэндээ ирэх энэ магадгүй 3-аас 5 жилийн хугацаанд энэ супер прагматик ийм нөхцөл байдал дээр бодит харилцааны цаг үе дээр дипломат алба өөрөө мэргэжлийн байх ийм шаардлага үүсэж байна шүү дээ. Магадгүй 40, 50 жилийн өмнө бол хамаагүй улс төрийн албан тушаалтнууд байж болдог байсан байх. Тэгэхээр одоо энэ жил бол лав 20, 30 элчин сайд нарын хугацаа дуусаж байгаа.

Сая энэ хаврын чуулганаар Элчин сайд нарыг шинээр томилох асуудлууд орж ирэх асуудал яригдаж байсан. Энэ ямар түвшинд байна вэ.

Ямар бодлоготойгоор оруулж ирэх гэж байна вэ? Ямар шалгуур шаардлага хангасан хүмүүсийг та хэд оруулж ирье гэж бодож байгаа юм. Энэ дээр нэг мэдээлэл өгөөдхөөч. Тэгээд төсвийн гүйцэтгэл угаасаа удахгүй ингээд орж ирнэ. Тэрэн дээр бид нар ер нь танай энэ дипломат байгууллагын чинь томилгоотой холбоотой, сүүлийн үед хийгдээд байгаа асуудлуудтай холбоотой бас мэдээлэл ер нь холбогдох мэргэжлийн Байнгын хорооны хувьд бид нар сонсох ёстой гэж харж байгаа юм.

Их Хурал бол мэдээж Ерөнхийлөгчийн санал болгосноор Элчин сайдыг бол оруулж ирж томилох асуудал яригдана. Засгийн газар дотроо мэргэжлийн бус хүмүүсийг улс төрийн намуудын шахалтаар, шаардлагаар, Консул болоод элчин зөвлөхүүдээр мэргэжлийн бус асуудлуудыг томилж байгаа асуудал байгаа. Энэ дээр нэг тодорхой мэдээлэл өгөөч. Энэ асуудлаа ч гэсэн төсвийн гүйцэтгэл дээр та хэд ер нь өөрсдөө мэдээлэл юмаа бэлтгээд оруулж ирж танилцуулах ёстой гэж харж байна. Гадаад яам.

Мөнхтүшиг дарга 6 номер.

Л.Мөнхтүшиг: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя.

ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга. Мөнхтүшиг дипломат албыг бэхжүүлэх хүрээнд ялангуяа энэ олон улсын харилцааны ээдрээтэй томоохон их гүрнүүдийн энэ хоорондын маргаан зөрчилдөөн энэ хурцдаж байгаа энэ үед манайх шиг хөгжиж байгаа орны хувьд бол улс төр дипломатын аргаар аюулгүй

байдал, тусгаар тогтнолоо хамгаалах ийм үндсэн чиг үүрэгтэй. Яамны хувьд бол хүмүүсээ бэхжүүлэх мэргэжлийн байлгах дээр бид онцгой анхаарч байгаа.

Энэ хүрээндээ бид энэ ондоо Дипломат албаны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар яг судалгааны ажлууд нь хийгдээд боловсруулах ажлууд нь хийгдээд явж байгаа. 2023 онд Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос 2 тоот нууцын горимоор гарсан тогтоол байдаг. Энэ хүрээнд сая Тэмүүлэн гишүүний хэлсэн Гадаад яамны үйл ажиллагааг нь илүү судалгаан дээр суурилсан мэргэжлийн байхтай холбоотой тэр дундаа судалгааны дипломат академийн бүтцийг ярьж байсан.

Тэгэхээр энэ асуудлуудыг бид оруулах гээд яамдаас санал аваад явж байна. Харамсалтай нь 2023 онд бол Засгийн газар дээр дэмжигдээгүй. Сургалтын байгууллага Удирдлагын академи гэж байхад тусдаа ингэж Дипломат академи гэж яах гэж байгаа юм бэ гэдэг үндэслэлээр унаж байсан юм байна лээ. Тэгэхээр бид нар энэ оны хувьд бид нар онцгой анхаараад яамдтайгаа ч ингээд учир байдлыг танилцуулаад засгаас санал аваад явж байгаа. Зүгээр бүтцийн хувьд бол улсын төсөвт төдийлөн өндөр ачаалал өгөхгүйн үүднээс яамныхаа бүтэцтэй байлгах их тийм прагматик байдлаар цөөн орон тоотой байхаар ингэж төлөвлөж байгаа. Эхний асуудлын хувьд.

Хоёр дахь асуудлын хувьд бол энэ томилгоотой холбоотой асуудал байгаа. Тэгэхээр дипломат албыг бэхжүүлэх ёстой гэдэг дээр таны хэлснийг бид бүрэн хэрэгжүүлж ажиллахын төлөө ажиллаж байна. Энэ хүрээндээ бол бид сая дипломат албаны шалгалтуудыг бол маш өндөр хатуу ийм хяналт доор ТА3-тэй хамтраад хийсэн. Өнгөрсөн зунаас эхлээд Төрийн албаны зөвлөл үндэсний аудитын байгууллагуудтай хамтраад гарсан зөрчлүүдийг арилгах ажлуудыг хийгдээд явж байгааг танд хэлье.

23 Элчин сайд нарын томилолтын хугацаа энэ онд дуусахаар байгаа. Тэгээд яг Дипломат албаны хуульдаа томилолтын хугацаа 4 жил гэж заасантай холбоотойгоор яг өнөөдрийн байдлаар энэ Элчин сайд нарын 4 жил нь яг бүрэн дуусаагүй байна. Яг 4 дуусах тогтсоны дараагаар Гадаад харилцааны сайд Ерөнхийлөгчтэй зөвшилцөөд элчин сайд нарын томилгооны асуудлыг оруулж ирнэ ээ. Тэгээд Элчин сайд нарын томилгоог мэргэжлийн байлгах дээр бол Гадаад харилцааны сайдын өгсөн чиглэлийн дагуу илэрхийлсэн байр суурийн дагуу ГХЯ ажиллаж байгаа гэдгийг танд дуулгая.

Засгийн газраас тэр томилгоотой холбоотой асуудлууд байгаа. Бид нар бүх томилогдож байгаа хүмүүс дээрээ өндөр шаардлага тавьж, хуулийн дагуу шаардлагууд шалгалтуудаа аваад явж байгааг танд хэлье ээ.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр Засгийн газар дотроо шийдэж байгаа саяын тэр консул болоод элчин зөвлөхтэй холбоотой асуудлууд дээр ямар нэг мэргэжлийн бус томилгоо бол хийгдээгүй гэж үзэх үү? Одоо улс төрийн нам хүчнээс чинь 30, 40 хүнийг ч гэдэг юм уу 40, 50-аар нь улс төрийн намаас албан тоотоор, бичгээр, тохиролцоогоор ингээд дипломат албыг арилжааны байгууллага болгож байгаа юм шиг байдлаар амралт зугаалгын газар болгож байгаа юм шиг байдлаар томилгоо хийж байгаа. Ийм ярианууд явж байна. Тэгэхээр энэ хэр бодитой юм

бэ? Та нар энэ асуудал дээр ажил хэрэгчээр яг мэргэжлийн талаас нь асуудалдаа хандаж чадаж байна уу? 6 номер.

Л.Мөнхтүшиг: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя Мөнхтүшиг.

Төрийн тусгай алба, дипломат алба, төрийн тусгай алба, сошиал орчинд явагдаж байгаа мэдээлэл бол яг бодит байдалтайгаа бол ташаа. ГХЯ бол Дипломат албаны хуулиар тавьсан шаардлагын дагуу тухайн албанд томилохоор нэр дэвшүүлж байгаа хүмүүс дээр бид нар шаардлагаа тавьж цөөн тооны томилгоо хийсэн. Энэ дээр гэхдээ бид танд танилцуулсан дипломат албаны хуульд тавьсан шалгуурын дагуу шалгалт аваад томилсон тохиолдол бий. Гэхдээ энэ тоо бол тийм квот гэдэг юм уу тийм зүйлээр томилгоо хийгдээгүй гэдгийг танд хариуцлагаар мэдэгдье ээ.

Г.Тэмүүлэн: Ойлголоо. тэгээд тийм биш байвал сайн байна. Тэгээд төсвийн гүйцэтгэл орж ирэхэд яг энэ томилгоотой холбоотой тэр дундаа Засгийн газар дотроо шийдээд байгаа энэ асуудлуудаа нэг бүрчлэн мэдээллүүдийг нэгтгээд Байнгын хорооны гишүүдэд энэ асуудлуудаар мэдээллийг хүргээд ингээд тодорхой хэмжээнд бид нар төсвийн гүйцэтгэлийн хүрээнд бол мэдээлэл сонсоно. Тэгэхээр мэдээллээ яамнаасаа сайтар бэлтгээд оруулж ирээрэй гэдэг зүйлийг хэлэх байна.

Төрийн алба болоод дипломат албаныхаа шаардлагуудыг хэрхэн хангасан юм, хэр дадлага туршлагатай юм, мэргэжлийн ур чадвар нь байгаа юм уу үгүй юм уу гэдэг асуудлууд дээр. Жангабыл гишүүн асуулт асууя.

Х.Жангабыл: Надад хэд хэдэн асуулт байна аа. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд 1.1.2 дээр бүсийн ялгаатай татвар санхүүгийн бодлогыг тодорхойлж хэрэгжүүлнэ гээд заачихсан байна. Тэгэхээр баруун бүсийн нутаг дэвсгэрт ямар бодлого барих юм. Баруун бүс бол та бүхэн мэдэж байгаа дэд бүтэц сул хөгжсөн, уур уурхай ч нэг их байдаггүй, бараа товар нь асар их өндөр үнэтэй Улаанбаатар хотоос авто тээврээр 2 мянгаад километр тээвэрлэж аваачдаг өртөг өндөртэй бараагаар ард иргэд бол хангагддаг юм аа.

Тэгэхээр ер нь ямар бодлого барих гэж байна? Нэг дэх асуулт.

Хоёр дахь асуулт. Баруун бүсийн амьжиргааг залгаж байгаа Цагааннуурын боомт байгаа. Энэ Цагааннуурын боомт дээр чөлөөт бүс гээд хэдэн жилийн өмнө зарласан, чөлөөт бүс нь хөдөлдөггүй. Ямар ч үйл ажиллагаа явуулдаггүй. Энэ Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусгачихсан юм байна уу? Онцгой байдлын газраас нэмж асууя. Цагаан нуурын боомтод газрын тосны бүтээгдэхүүн хадгалах савнууд байж байгаа. Социализмын үед баруун 5 аймгийг газрын тосны бүтээгдэхүүнээр хангаж байсан. Олон жил болж байна. Ямар ч ажиллагаагүй. Энэ савнуудыг эдийн засгийн эргэлтэд оруулаад ажиллуулах бололцоо боломж байдаг болов уу? Би байнга асуудаг. Энэ чөлөөт бүс энэ нэг газрын тосны бүтээгдэхүүн хадгалдаг савнууд байгаад байдаг. Энийг бол эдийн засгийн эргэлтэд оруулах боломж бололцоо байдаг болов уу гээд асуулт асууя.

Гуравдугаарт, ГХЯ-аас Цагааннуурын боомт бол өмнө нь дээр үед 7 хоногийн 7 хоногт нь ажиллаж байсан. Одоо бүтэн сайн өдөр амардаг амралтын өдөр. Украйны дайнтай холбоотой асар их ачаалал нэмэгдэж байгаа. 2 талаасаа бол дугаарлаж зогсдог иргэд бүр хонон, өнжин заримдаа гардаг тийм тохиолдлууд байдаг. Ялангуяа зуны цагт. Тэгэхээр энэ 7 дахь хоногийг нэмж ажиллуулах, цаашлаад 24 цагаар ажиллах саналыг бол удаа дараа хүргэсэн. Ямар ч хариулт байхгүй. Энэ дээр та тодорхой хариулт өгөөч.

Иймэрхүү л асуудлууд байна даа.

Г.Тэмүүлэн: Жангабыл гишүүний асуултад хариулъя. 3 номер.

И.Батхүү: Жангабыл гишүүний асуултад хариулъя аа. Эдийн засгийн хөгжлийн яамны ТНБД Батхүү. 2026 оны улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө 1.3, 1.2 дээр Цагаан нуур чөлөөт бүсийн эхний ээлжид цахилгаан хангамж болон гүний худгийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх гэдэг ажил туссан байгаа. 4.2 тэрбум төгрөг. Ер нь бол энэ бодлогын үндэс нь бол Засгийн газрын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан арга хэмжээний эхний жилд хийгдэх ажлыг нь 2026 онд хийгдэх ажлыг нь тусгасан. Татварын ялгаатай бодлогыг нь Сангийн яамнаас хариулах уу?

Г.Тэмүүлэн: Татварын асуудал нөөцлөвөр, савтай холбоотой асуудал байгаа. Сангийн яам Тэлмүүн дарга 2 номер.

Б.Тэлмүүн: Сангийн яам Тэлмүүн. Татварын ялгаатай бодлоготой холбоотойгоор бол хэд хэдэн хууль батлагдсан хэрэгжиж байгаа. Энэ дээр үндсэн 2 асуудал байгаа.

Нэгдүгээрт бол хөнгөлөлт чөлөөлөлттэй холбоотой асуудал.

Хоёрдугаарт бол татварын хувь хэмжээ ялгаатай байх гэсэн ийм 2 асуудал байгаа. Бүсийн хөгжилд томоохон нөлөө үзүүлэхүйц ач холбогдолтой төслүүд хэрэгжүүлэхэд тухайн аймаг бүсүүдээс санал гаргаад Засгийн газрын хурлаар хэлэлцүүлээд бүтээн байгуулалтад шаардагдах барилгын материал тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлөх импортын барааны НӨАТ-ыг 4 жилээр хойшлуулах ийм боломж бүрдсэн. Энэ дээр бол баруун аймгаас бол яг энэ татварын хөнгөлөлт төлөвлөлтөд оруулахаар гарсан санал одоогоор байхгүй байна.

Хоёрдугаарт дийлэнх татварууд бол орон нутаг бие даан тогтоодог аймгуудын иргэдийн төлөөлөгчдөөр бие даан хувь хэмжээг тогтоодог. Тэгэхээр энэнтэй холбоотойгоор бол.

Г.Тэмүүлэн: Нэмээд 2 номер. Гүйцээж хариулъя. 2 номер.

Б.Тэлмүүн: Үүнтэй холбоотойгоор бол аймгийн ИТХ-д татварын хувь хэмжээг бууруулах, дээрээс нь яг бүсчилсэн хөгжилд шаардлагатай төслүүдийнхээ татварыг тусгайлан хөнгөлөх ийм боломжууд бүрдсэн. Үүн дээр газрын төлбөр үл хөдлөх хөрөнгийн албан татвар. Дараагийн арга хэмжээ нь бол

Засгийн газраас болон Улсын Их Хурлаас тогтоодог импортын барааны гаалийн татварыг бүсээр буюу боомтоор ялгаатай тогтоох ийм боломжууд бүрдсэн байгаа. Үүнтэй холбоотойгоор бол аймгууд бүсүүд өөрсдөө саналаа гаргаад Засгийн газар болон Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх ийм боломж байгаа. Тэгэхээр бүсчилсэн хөгжилтэй холбоотой импортын гааль, НӨАТ, үл хөдлөх хөрөнгө, газар, орлогын татвартай холбоотой хууль, эрх зүйн орчнууд үргэлжилж байна.

Засгийн газраас өргөн мэдүүлэхээр боловсруулж байгаа Татварын багц хуулийн хүрээнд санал авч байгаа. Үүн дээр нэмэлтээр орон нутаг бүсүүд дээр ямар төрлийн татварын зохицуулалтууд байж.

Г.Тэмүүлэн: Дараагийн асуулт дээр нь хэн хариулах вэ? Гадаад яам 6 номер.

Л.Мөнхтүшиг: Жангабыл гишүүний асуултад хариулъя. Цагаан нуур боомтын хувьд бид орон нутгаас болон ААН-үүдээс ирсэн хүсэлтийн дагуу дипломат шугамаар Оросын талд удаа дараа тавьж ирсэн юм аа. Тэгэхээр энэ дээр нэг гол асуудал нь боомт гэхээр 2 талдаа төлөлтөө, хөрөнгө оруулалтаа уялдуулах ёстой байгаад байдаг. Оросын талын төлөлтөд хөрөнгө оруулалт, дэд бүтэц, бүтээн байгуулалт дээр яг хангалттай төсөв мөнгө нь тавигдахгүй удаашраад байгаа асуудал байгаа гэдгийг айлын тал хэлж байгаа. Өнгөрсөн оны 10 сард хил орчмын комисс гэж Засгийн газар хороодын дэд комисс гэж байдаг. Боомтын сайд ахалдаг. Энэ жил Улаанбаатар хотноо өнгөрсөн онд Улаанбаатар хотноо хуралдсан. Одоо энэ жил Москва хотноо хуралдана. Удахгүй Гадаад хэргийн дэд сайд нарын уулзалтаар энэ асуудлуудыг тавих гэж байгаа гэдгийг танд хэлье.

Г.Тэмүүлэн: Нөөцлөвөр газрын тостой холбоотой асуудал дээр хэн хариулах вэ? Ариунбуян дарга хариулах уу? Тэгье 4 номер.

Г.Ариунбуян: Цагаан нуурын боомтод байгаа улсын нөөцийн шатахуун хадгалах сав бол 1970-аас 1975 онд ашиглалтад орсон. Хуучин нефть хангамжийн зориулалттайгаар ашиглаж байгаад улсад буюу улсын нөөцийн манай мэдэлд ирсэн. Энийг эдийн засгийн эргэлтэд оруулах буюу ингээд шатахуун хадгалаад эргээд борлуулаад хангамжийг нэмэгдүүлэх хүрээнд ажиллая гэвэл сэргээн засварлах тэгээд металл хийцийн оношилгоо гээд бусад зардалтай холбоотой нэлээд санхүүжилтийн асуудал яригдах юм байна лээ. Тэгээд энэ санхүүжилтээс болоод ингээд шийдэгдэхгүй өнөөдрийг болж хүрч байна аа.

Г.Тэмүүлэн: Гишүүд 1 дүгээр заалттай холбогдуулаад асуулт асууж дууслаа. Заалт бүрээр нь хэлэлцэж байгаа.

2 дугаар заалттай холбогдуулаад асуулт асууж үг хэлэх гишүүд байна уу? Батсүмбэрэл гишүүн үү? Батсүмбэрэл гишүүн. Хосбаяр гишүүн байна. Хосбаяр, Батсүмбэрэл гишүүдээр тасалъя.

Батсүмбэрэл гишүүн.

Н.Батсүмбэрэл: Сая юу яаж байгаа юм байна тэр гаргаж байгаа санал маань энэ чинь 4.6.3 дахь заалт болгож санал оруулж байгаа. Түрүүний гаргадаг санал бол 1.

Хоёрт нь тэр Эдийн засгийн яамныхан анхаарч байгаарай. Та бүхний гаргасан тэр төрийн албаны реформ гэдэг дээр төрийн албаны шинэчлэлийг хийж чиг үүргийн давхардлыг арилгаж төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан, төрийн албыг бэхжүүлнэ гэчихсэн байж байгаа. Тэгээд энэ дотроо багш эмч нарыг оруулчихсан байна. Тэгээд нөгөө онцгой байдлын аврагч нар маань хэмнэгдэх нь байна шүү дээ. Нөгөө 169 анги маань 77 ажиллаж чадахгүй байхад нэмээд хэмнэчих нь байна. Тэгээд хэнийгээ хэн нь аврах вэ? Тэгээд энэ онцгой байдлын алба хаагч нарыг энэ дээр нэмж оруулж болохгүй юу? Тэгээд энэ би гаргаж байгаа санал тэр багш эмч нар зөв. Багш, эмч нарынхаа ард таслал аваад онцгой байдлын аврагч нар. Аврагч нараа хэмнэчихмээргүй байна шүү дээ. Тэгээд манай сайд нарын гэрт гал гараад байна лээ шүү дээ. Тэр дарга нарын гэрт тэгээд гал мал гарвал яах юм. Усанд үерт автвал яах юм. Энд тэнд өвөл явж байгаад хөлдөж баривал яах юм. Ядаж энийгээ бодоцгоох хэрэгтэй. Тэгээд энэ онцгой байдлын аврагч нарыг Батхүү дарга хасахгүй байж болох уу? Эдийн засгийн яамныхан Эрдэнэбат дарга. Мөнгөнсүх дарга.

Тэгээд та хэд эд нар дээр тодорхой хариулт өгөөч.

Г.Тэмүүлэн: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. 2 номер.

Ц.Эрдэнэбат: Эдийн засаг, хөгжлийн яам Эрдэнэбат Батсүмбэр гишүүний асуултад хариулъя. Бид нар тэр 9 хувь урьдчилсан тооцоо гэж би түрүүн хэлсэн. Урьдчилсан тооцоо явж байгаа. Энэ яг нарийвчилсан төлөвлөгөө гарна. Тэр үед таны саналыг тусгаж ажиллая.

Г.Тэмүүлэн: Батсүмбэрэл гишүүн нэмж тодруулъя.

Н.Батсүмбэрэл: Наадах чинь яг хулхидна шүү. Тэгэхлээр ингэнэ багш, эмч, таслал онцгой байдлын аврагч хэдүүлээ тогтчихъё эндээ тэгээд ингэж байж хэдүүлээ яг орно. Тэгэхгүй бол наадах чинь сая хэллээ шүү дээ. Танай гэрт чинь гал гарвал яах вэ? Энд тэнд үер ус бол яах вэ? Хэдүүлээ энийгээ бодолцож ажлаа явуулъя. Тэгэхээр яг тэр үед гэхгүй энийгээ хэдүүлээ гаргаж байгаа санал дээрээ найруулга энэ чинь найруулгын чанартай байна шүү дээ. Оруулж болдог тийм ээ. Би тэр зарчмаар ингээд найруулаад таслал аваад онцгой байдлын аврагч нараас бусад гээд оруулчихъя гэсэн саналтай байна шүү.

Г.Тэмүүлэн: номер Эдийн засаг хөгжлийн яам.

Ц.Эрдэнэбат: Эрдэнэбат гишүүнээ бид нар одо яг энэ дээр ингээд өөрчлөлт хийх эрхгүй. Та саналаа гаргаад зарчмын зөрүүтэй саналаар Байнгын хороон дээр явсан нь дээр байх аа. Тэгэхгүй бол бид яг юу гэдэг юм? Нөгөө боломжгүй учраас яг саналыг дэмжиж байгаа. Бид нар яг өргөн барьчихсан энэ

төсөл дээрээ шууд өөрсдөө дур мэдээд өөрчлөлт оруулах эрхгүй байгаа. Та ойлгоорой.

Г.Тэмүүлэн: Батсүмбэрэл гишүүн нэмж тодруулъя.

Н.Батсүмбэрэл: Тэгэхээр сая протоколд орлоо шүү дээ. Эдийн засгийн яам татгалзахгүй дэмжиж байна гэдгээ хэлчихсэн. Тэгэхээр энэ асуудлыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны протоколд оруулаад холбогдох Байнгын хорооны эцсийн санал хураалт дээр нь энэ чинь 169 нэгжийн 77 нь ажиллаад байдаг. Бүгдээрээ өвөл болохоор уул хаданд явдаг, зун болохоор амралт зугаалгад явдаг. Үер ус, цас зуд, гал гээд олон асуудал дээр аврагч нар хэрэг болдог. Тэр нь аврагч нарын асуудлыг эндээс хэмнэлтэд аврагч нараа оруулахгүй байя л гэсэн санаа оруулж байна шүү. Өөрөөр хэлбэл хэмнэлтэд дарга нар, сайд нарыг оруулж болно, аврагч нарыг оруулж болохгүй.

Г.Тэмүүлэн: Санал хэллээ. Хосбаяр гишүүн асуулт асууя.

Г.Хосбаяр: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Нэгдүгээрт нь Гадаад яамнаас асуух юм. Ер нь ирэх жил энэ гадаадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын хөрөнгө оруулалтад хэр анхаарч байгаа вэ. Жишээлбэл Япон улсад байгаа ЭСЯ гэхэд байр нь нурах болчихсон гээд ингээд мэргэжлийн байгууллагын дүгнэлт юмнууд гарчихсан юм байна лээ. Тэгэхээр ер нь одоо энэ гадаадад байгаа төлөөлөгчийн газруудын хөрөнгө оруулалт тэр зүйлд ер нь аль зэрэг анхаарч байгаа вэ? Тэнд хөрөнгө тавьж байгаа юу? Япон улсын тэр ЭСЯ гэхэд 20 сая доллар хэрэгтэй гэсэн ийм зүйл ярьж байсан. Тэгэхээр бас гадаадад байгаа тэр ажиллаж амьдарч байгаа, ажиллаж байгаа Монголын төрийг төлөөлж байгаа хүмүүсийнхээ ажиллах амьдрах нөхцөлийг сайжруулахад анхаарах байх гэж бодож байна.

Хоёрдугаарт нь гадаадад байгаа төр төлөөлж байгаа хүмүүсийн хүүхдүүдийн сургалтын төлбөрт 2024 онд ямар төсөв байсан бэ? Ирэх 2026 онд ер нь өсөж байгаа юу? Энэ хэрвээ нууц биш бол энийг нэг хэлж өгөөч.

Гуравдугаарт нь энэ гадаадын банк, гадаадын банкны салбар нэгж байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ гээд энэ 3.3.2 дээр оруулчихсан байгаа. Тэгэхээр миний санаж байгаагаар бол гадаадын банкны төлөөлөгчийн газрууд байдаг шүү дээ тийм ээ. Тэгэхээр одоо яг 2026 онд энэ 3.3.2 дээр гадаадын банкны салбар нэгж байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ гэсэн байна. Тэгэхээр яг ямар нөхцөл бүрдүүлж өгөх гээд байгаа юм. Ямар дэмжлэг ямар бодлогын арга хэрэгсэл байгаа юм бэ гээд.

Дараа нь гадаадын зээлээр хэрэгжиж байгаа төслүүдийн ажилтай сая бүтэн сайн өдөр Их Хурлын 5, 6 гишүүн явж танилцсан. Улаанбаатар хотод хэрэгжиж байгаа усны төсөл 461 сая доллар, усны компакт төсөл. Дараа нь Төв цэвэрлэх байгууламжийн өргөтгөл 262 сая доллар, дараа нь Солонго 1, 2 хороолол 280 сая доллар гээд нийтдээ тэрбум долларын гадаадын зээлээр хэрэгжиж байгаа төсөл үзсэн. 2025, 2026 онд дуусна гэж байгаа юм. Тэгэхээр энэний оронд нөгөө зөрүүнд бас нэг тэрбум долларын гадаадын зээл

хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх гээд байна шүү дээ. Энэ дээрээ яг ямар төслүүд оруулж ирж байгаа юм бэ? Энэнийх нь яг одоо эрэмбэ дараа нь байна уу? Тэгэхгүй бол зүгээр гэрээ хийчихсэн юм даа энийг заавал авна даа гээд авчих юм уу? Эсвэл нөгөө бүсчилсэн хөгжил нөгөө яг улс орны амин чухал асуудал тулчихсан асуудлуудаа шийдэх тал руу явах юм уу. Энэ дээр ер нь ямар төлөвлөгөө байгаа юм бэ гээд. Тэгээд тэр гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүд дээр ер нь олон алдаа дутагдал байна лээ дээ. Төсөвт өртөг нь хэт өндөр байна. Тэнд хамаг Монголын ажилчдыг өөр төсөвтэй учраас татаад авчхаж байна. Одоо тэр солонго 1, 2 хороолол гэхэд метр квадрат нь НӨАТ, гаалийн татвараас чөлөөлөгдөөд 4.5 сая төгрөгөөр босож байгаа шүү дээ. 280 сая долларын төсөл 900 гаран тэрбум төгрөгийн өртөгтэй. Тэгэхэд буцаагаад 213 мянган м2 яг цэвэр орон сууцын талбай байгаа. Тэгээд хуваагаад үзээрэй та бүхэн. НӨАТ, гаалиас чөлөөлөгдөөд улсын үнэгүй газар дээр 4 сая 500 мянгаар орон сууцын хороолол бариад л бид нар хувийн хэвшилтэйгээ өрсөлдөөд байна шүү дээ.

Тэгэхээр энэ гадаадын зээл тусламжийг ер нь үр ашиг төсөв энэ юман дээр ер нь нэг онцгой анхаарах цаг болсон юм биш үү. Бид нар тэгээд зээл гэхээр л нэг хямдхан бага хүүд нь хууртагдаад хэт өндөр өртөгтэй төсөл хэрэгжүүлээд байна шүү. Тэгэхээр хамгийн гол асуудал нь тэрбум доллар сулрахаар тэрнийхээ оронд яг ямар төсөл хөтөлбөрүүдийг эрэмбэлээд байгаа юм бэ?

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. 3 номер. Дараа нь Гадаад яам.

И.Батхүү: Эдийн засаг, хөгжлийн ТНБД Батхүү. Хосбаяр гишүүний асуултад тэр гадаадын банктэй холбоотой асуултыг хариулъя аа. Өнгөрсөн хугацаанд банкны салбарын реформын асуудал Валютын сангийн хөтөлбөр хэрэгжих үеэс эхлээд яригдаж ирсэн. Энэ салбарын засаглалыг сайжруулах, ялангуяа хямд өртөгтэй эх үүсвэрийг татаж оруулах тал дээр бас нэлээн их анхаарал тавьж ирсэн. Энэ ажлыг бодит ажил хэрэг болгох үүднээс 2026 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд энэ талаар тусгасан байгаа.

Энэ гаднын хөрөнгө оруулалттай банк орж ирснээр ямар ач холбогдолтой юм гэх юм бол энэ гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд тэр Гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг дээшлүүлэх томоохон төслүүдийн санхүүжилттэй холбоотой найдвартай орчныг бүрдүүлэх ийм ач холбогдолтой байгаа. Бас макро эдийн засгийн хувьд бас инфляцыг бууруулах, мөнгөний тогтвортой байдлыг хангах зэрэг олон төрлийн ач холбогдолтой учраас энэ бодлогын салбарын шинэчлэлийн бодлогын хүрээнд түлхүүр болгож оруулсан байгаа. Энэ дээр яг бодитой хэрэгжүүлэгч нь Монголбанк л байгаа л даа. Ер нь тийм.

Г.Тэмүүлэн: 6 номер Гадаад яам.

Л.Мөнхтүшиг: Хосбаяр гишүүний асуултад хариулъя.

ГХЯ-ны ТНБД Мөнхтүшиг. Төсөвтэй холбоотой эхний асуудал дээр дипломат албыг бэхжүүлэх хүрээнд бид хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулах болон ер нь шат дараатай маш олон ажлыг хийхээр төлөвлөчихсөн ажил нь явж

байна энэ ондоо. Тэгээд энэ хүрээндээ энэ дипломат алба бол төрийн тусгай алба, харамсалтай нь өнгөрсөн хугацаанд ерөөсөө төрийн тусгай албынхаа хүрээндээ ажилтнуудын нийгмийн асуудалд анхаарч байгаагүй ирсэн ийм байдаг юм байна лээ. Тэгээд энэ дээр бид онцгой ийм өөрчлөлт хийхээр Байнгын хорооны гишүүд ГХЯ дээр ажиллах үеэр бид саналаа төлөвлөж байгаа ажлаа танилцуулж байсан.

Тэгэхээр манай яамнаас бол төсвийн хүрээний мэдэгдэлд бол саналаа өгчихсөн байгаа. Гэхдээ мэдээж төсвийн бодит боломж эд нар хэр байна, тэр яригдах байх. Токиогийн байрны асуудлын хувьд бол ГХЯ-нд ирэх онд Токио дахь ЭСЯ-ны асуудлыг бол 1 дүгээрт эрэмбэлж байгаа. Энэ нь өөрөө маш өндөр эрсдэлтэй болчихсон. Газар хөдлөхөд.

Г.Тэмүүлэн: 6 номер нэмээд хариулъя.

Л.Мөнхтүшиг: Тэгээд би Токиогийн ЭСЯ-ны хувьд бол бид төсвийн хэд хэдэн хувилбар байгаа. Төсөвт ачаалал өгөхгүй хувилбар. Ачаалал даах буюу сая таны хэлсэн 20 сая гаруй доллар шинэ судалгаа тооцоогоор 30 сая хүртэл доллар одоо байгаад байгаа. Одоогийн газар дээр нь шинээр барина гэвэл. Тэгэхээр бид хэд хэдэн хувилбарыг ойрын хугацаанд ТӨБЗГ-тайгаа хамтраад шаардлагатай бол Засгийн газарт танилцуулаад ингээд төлөвлөж байгаа. Ирэх жил бол Токиогийн асуудлыг бүрэн шийднэ гэсэн ийм төлөвлөгөөтэй байна.

Сургалтын төлбөрийн асуудлыг та тавилаа. Дипломат албанд хилийн чанадад 350 орчим хүн ажилладаг. Тэгэхээр төрөөс томилолт аваад явж байгаа ажилтнуудын хүүхдүүдийн сургалтын болон цэцэрлэгийн төлбөрийг төр даана гэдэг ийм хуулийн зохицуулалттай. Өнгөрсөн мөн энэ оны төсөв дээр 12 тэрбум төгрөг Дипломат төлөөлөгчийн газрын сургалтын зардалд суусан байгаа. Тэгэхээр бид энэ дээр онцгой анхаараад энэ жил төсвийн зарим тохируулга дотроо багц дотроо хийхээр зохицуулалтууд хийгдэж байгаа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Болсон уу Хосбаяр гишүүн. Сангийн яам 7 номер уу? 7 номер асчихсан байна.

Ж.Дэлгэржаргал: Хосбаяр гишүүний асуултад хариулъя.

Сангийн яам Дэлгэржаргал. Гадаад зээлийн төслүүдийн хувьд 2 ангилалд авч үзэж байгаа. Одоо яг хэрэгжээд хэлэлцээр нь Улсын Их Хурлаар батлагдаад Улсын Их Хурлаар батлагдахдаа ямар төслүүд хэрэгжүүлэх вэ? Ямар дүнтэй зээл авах вэ? Үндсэн төлбөрүүд, дуусах хугацааг нь бүгдийг нь Их Хурлаас ингээд батлаад өгч байгаа. Энэ Их Хурлаас баталсан хэрэгжиж байгаа улсын хэмжээнд 89 төсөл явж байгаа. Нийт зээлийн амлалтын дүнгийнх нь бид нар ашиглах шаардлагатай үлдэгдэл 12.6 их наяд. Энэ 12.6 их наядаас бид нар энэ 2025 онд 1.5 их наядыг ашиглахаар төсөв дээр батлагдсан.

Тэгэхээр цаана нь 11 их наяд бол 2029 он хүртэл ашиглаж дуусах шаардлагатай. Тэгэхээр таны хэлсэн 3 төслүүдийн хувьд бол зарим нь энэ он дуусаад одоо жишээ нь Мянганы сорилтын сангийн Усны компакт гэрээ тусламжийн эх үүсвэр учраас зээлийн ашиглалт дээр 1.5-д хамаарахгүй.

Тэгэхээр энэ төслүүд маань дуусгаад дараагийн хэрэгжиж байгаа төслүүдээсээ бид нар яг нэг энэ хугацаандаа ашиглалтаа тавиад явна. Нөгөө нэг ангилал нь бол хэлэлцээрт байгаа төслүүд байгаа. Улс өөрөө Улсын Их Хурлаар орж батлагдаагүй байгаа төслүүдийн хувьд тодорхой хэмжээгээр бэлтгэл ажил судалгаанууд нь 2 талаасаа хийгдээд явж байгаа.

17 их наядын шаардлага байгаа. Тэгэхээр Сангийн яамны хувьд бол энэ төслүүдийг аль аль түвшнийх нь төслүүдийг эрэмбэлээд тэргүүн шаардлагатай, ач холбогдолтой, тодорхой үр дүн гарах төслүүдийг хугацаанд нь дуусгах ийм бодлого барьж байгаа.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүн нэмж тодруулъя.

Г.Хосбаяр: Тэгээд яах вэ энэ нөгөө дуусаж байгаа төслүүд ойлгомжтой. Оронд нь нөхөж тэр орон зай тэр нөхөж орж ирэх төслүүд нь сая таны яриагаар бол Их Хурлаар баталчихсан юм чинь гэрээ тэр хугацаандаа гээд байна шүү дээ. Жишээлбэл тэр Кувейтийн сан билүү Арабын сангаас нөгөө Лүн хүртэлх зам хийх асуудал ярьж байгаа. Нийтдээ 2.8 тэрбум долларын зээл гээд байгаа шүү дээ. Тэр ер нь яг хэзээ орж ирэх юм. Хэзээнээс эхлэх юм. Ер нь зүгээр дахиж энэ танайхаас санал боловсруулж оруулж ирж болохгүй юу? Тэгэхгүй бол ний нуугүй хэлэхэд зарим төсөл чинь өртөг нь өндөр ач холбогдол багатай төсөл хүртэл зарим нь байгаа шүү дээ. Зүгээр ингээд яах вэ урьд нь хийчихсэн юмаа бид юу ярих вэ зүгээр тэгэхдээ ямар ч байсан дахиад авч үзэх шаардлага байгаа юм биш үү л гэж ингэж хараад байна л даа. Тэгэхээр энэ тал дээр ямар байр суурьтай ер нь ямар төлөвлөгөөтэй юм.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. 7 номер Сангийн яам.

Ж.Дэлгэржаргал: Хосбаяр гишүүн асуултад хариулъя. Кувейтийн сангийн хувьд бол яг Лүнгийн 4 эгнээ зам 6 эгнээ болгох асуудал. Зураг төсөв ТЭЗҮ-ийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгээд явж байгаа. Энэ онд дуусна. Кувейтийн талдаа хэлэлцээрийн түвшинд явж байгаа. Тэгэхээр энэ төслийн хувьд бол Улсын Их Хурлаар орж батлагдсаны дараа төсөв дээр ашиглалт талдаа хэрэгжиж эхлэхээр Их Хурлын 2025 оны төсөв батлагдсантай холбогдуулаад гарсан 52, 54 дүгээр тогтоолуудын хүрээнд ер нь гадаад зээлийн хэрэгжиж байгаа хэлэлцээрт байгаа төслүүдийг бид нар эрэмбэлээд ялангуяа 2025 онд хэрэгжиж байгаа төслүүдээс бид нар шаардлагагүй зарим төсөл дотор нь зөвлөх үйлчилгээ сургалтуудыг хасаад 173 тэрбумын зохицуулалтыг гаргаад бүтээн байгуулалтын төслүүд дээр тавьсан ийм арга хэмжээнүүдийг хийсэн.

Нэгэнт Улсын Их Хурлаар батлагдаад, яг донор санхүүжилт, доноруудын санхүүжилтээр явж байгаа төслүүд дээр яг дундаас нь зогсох асуудал дээр нэлээн нухацтай хандах ийм шаардлагатай байдаг. Ер нь бол төслүүд дээр дотор нь яг эрэмбэлээд шаардлагагүй ажлуудыг нь хойшлуулах, зогсоох.

Г.Тэмүүлэн: Нэмж хариулах уу? 7 номер.

Ж.Дэлгэржаргал: Энэ Их Хурлын тогтоолуудын хүрээнд яг тодорхой бүтээн байгуулалт, дэд бүтэц, тодорхой үр дүнд гарах ажил дээр нь илүү төвлөрч

тийшээгээ санхүүжилтийг нь хуваарилах ажлыг бол хөгжлийн түнш байгууллагуудтай Сангийн яамны хувьд хийгээд ингээд явж байгаа.

Г.Тэмүүлэн: Хасбаяр гишүүн болсон уу? Нэмж тодруулъя Хасбаяр гишүүн.

Г.Хосбаяр: Хувийн компаниуд жилд бараг 20 мянган орон сууц барьж өнгөрсөн оны статистикаар гэхэд Монголын барилгачид 19600 орон сууц бариад ашиглалтад өгчихсөн байгаа юм л даа. Гэтэл төр хажуугаар нь орж ирээд л Солонго 1, 2 цаашаа ингээд л хорооллууд барих гээд л байна л даа. Тэгэхээр яах вэ одоо сайн эрэмбэлээрэй л гэж хүсээд байгаа юм. Түүнээс ингээд өөрсдөө хийж чадаж байгаа, хөрөнгө мөнгө нь байгаа хувийн хэвшил хийж байгаа юмыг дахиад төр ингээд л зээл аваад л бусад боломжтой хэрэгжих төслүүдийнхээ хамаг юмыг хаагаад л хэрэгтэй юмнуудаа хойш нь тавьж байгаад л орон сууц бариад л хувийн хэвшилтэйгээ өрсөлдөөд байхаар чинь энэ чинь ер нь зөв бодлого мөн үү тэ?

Тэгээд нөгөө орон сууц нь хямдхан биш. 4 сая 500 мянгын үнэтэй байгаа. Тэгээд ийм юм хийхээр бол тэгээд л гадаадын зээл тусламжийг зээлийг үр ашигтай зарцуулж байна гэж үзэхгүй л гэж бодоод байна л даа. Тэгэхээр энэ асуудлыг бас дахиад ярина аа. Тэгээд ойлголоо.

Г.Тэмүүлэн: 2 дахь заалттай холбогдуулаад гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Саяын Хосбаяр гишүүний хэлсэнтэй холбогдуулаад гадаад зээл тусламжтай холбоотой асуудал Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хамаарах асуудал байгаа. Тэгэхээр энэ гадаад зээл тусламжийн төлөвлөлт, хяналт, хариуцлагыг сайжруулах асуудлаар энэ өрийн удирдлагын менежменттэй холбоотой асуудлаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр мэдээлэл сонсоно.

Тэгэхээр Засгийн газар, Сангийн яам сая сүүлийн 10 жилийн хугацаанд энэ гадаадынхан зээл тусламж хөрөнгө оруулалтынхаа төлөвлөлттэй холбоотойгоор хийж хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдтэй холбоотойгоор мэдээллүүдээ бэлтгэнэ ээ. Тэгээд Байнгын хорооноос Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яаманд бид нар нэг албан ёсоор бичиг явуулж 6 сарын эхний 7 хоног дээр бол энэ мэдээллийг бол бүрэн дүүрэн сонсож Байнгын хорооны гишүүд нэг талдаа зөвхөн хүсэх биш энэчээ бид нар бол Байнгын хорооны хүрээнд бид нар хяналт хариуцлага тавих, шахаж шаардах бол үүрэгтэй. Хяналт тавих үүрэгтэй.

Тэгэхээр нэг талдаа Эдийн засгийн хөгжлийн яам ч гэсэн бас энэ асуудал дээр голлож оролцох ёстой байгаа шүү. Та бүхэн бол хуулиар олгогдсон үүрэг байгаа. Энэ Засгийн газрын өрийн баталгаатай холбоотой, зээл тусламжтай холбоотой асуудлууд дээр эдийн засгийн бодит үр өгөөжийг нь тооцдог байх ёстой. Тооцоо судалгааг нь Эдийн засгийн яам нотолж гаргаж ирдэг байх ёстой байгаа.

Тэгэхээр одоог хүртэлх энэ яригдаад байгаа 10 их наяд, 12 их наяд гэж яригдаад байгаа энэ зээл тусламжтай холбоотой асуудлууд дээр тус бүр дээр нь

бол та бүхэн нотолгоо, судалгаа, судалгаа, мэдээллүүдээ бол гаргаж нэгтгэж ирүүлсэн байх ёстой. Ингээд 6 сарын эхний 7 хоног дээр бол энэний өрийн удирдлагын менежменттэй холбоотой энэ олон улсын гэрээ, хэлэлцээр зээлтэй холбоотой асуудлууд дээр бол мэдээллээ бол та бүхэн бэлдэж ирүүлнэ ээ. Энэ дээр бол бас хариуцлагатай хандаж оролцоорой. Тэгээд гишүүдэд бол 6 сарын 1-ээс өмнө Байнгын хорооны хурлаас өмнө мэдээллийг сонсохоос мэдээллээр бол хангана гэдгийг бол хэлэх байна.

Ингээд 2 дахь заалттай холбоотойгоор гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

3 дахь заалттай холбоотойгоор асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

4 дэх заалттай холбоотойгоор Байнгын хорооны гишүүдээс асуулт асуух, үг хэлэх гишүүд байна уу? Үг хэлэх гишүүн байна. Анар гишүүнээр тасалъя. Анар гишүүн.

Ч.Анар: 2026 оны энэ хөгжлийн хөтөлбөртэй холбогдолтойгоор энэ Монгол Улсын Засгийн газар хиймэл оюун ухаан, биг дата энэ хөгжлийн хөтөлбөр дээр маш олон зүйл заалтаар бүх реформ дээр төрийн процессын дахин инженерчлэл, бүтээмжийг сайжруулах, цахимжуулах гэж төсөл заалтууд байгаа. Би өөрөө Их Хурал дээр тэр ажлын хэсгийг нь ахалж байгаа учраас нөхцөл байдлыг сайн мэдэж байгаа. Тэгэхээр 1 асуудлыг л ерөөсөө бид анхаарахгүй байгаад байна. Бид нар бүх юмаа цахимжуулаад нээлттэй болгоод урагшаа явах гэж байгаа зөв үү. Гэхдээ энэ кибер аюулгүй байдал гэдэг асуудал буюу суурь дэд бүтэц, зөөлөн дэд бүтцийн асуудал дээр ерөөсөө анхаарахгүй ойлголтгүй байна.

Гишүүд ч ойлголтгүй байна. Олон нийт ч ойлголтгүй байна. Энэ тэгэхээр бид нар урагшаа явахын тулд энэ заавал ч үгүй төмөр зам барихын тулд дэр мод тавих ёстойтой адилхан кибер аюулгүй байдалдаа онцгой анхаарах хэрэгтэй байна аа. Тэгж энэ дээрээ төсөв тавиад боловсон хүчнээ бэлтгэхгүй бол бүх мэдээллээ улстайгаа, иргэнтэйгээ задгай тавьчих гээд байна. Тэгэхээр энэ БХЯ-ан дээр би сая тодруулга хийлээ. Тэр Кибер командлалын төвийн байшингийн төсөв нь ууланд өгсөн юм байна. Эдийн засгийн хөгжлийн яаман дээр яагаад хасчихсан юм бэ? Тэрийг оруулахыг хүсэж байна. Би зарчмын зөрүүтэй санал гаргана. Дахиад тэр нэг кибер командлалын лицензийн асуудал ноднингоос хойш яригдаад шийддэггүй. Энэ асуудлаа ер нь Эдийн засгийн хөгжлийн яам Сангийн яам маань цаашдаа анхаарахгүй бол бид нар баахан мөнгөөр хийгээд цахимжилт хийгээд гэрийнхээ хаалгыг онгорхой орхиж байгаа айл шиг болох гээд байна шүү.

Энэ дээрээ анхаараасай гэж хүсэж байна. Үүнтэй холбогдуулаад бас Байнгын хорооны даргад энэ Кибер аюулгүй байдлын тухай хууль шинэчлэх шаардлагатай байна. Энэ бүтэц ч гэсэн өнөөдрийн нөхцөлд цаг үетэйгээ нийцэхгүй байна аа. Тэгэхээр энэ дээр бас кибер аюулгүй байдлын талаар үндэстний стратегийг шинэчлэн боловсруулах энэ хуулийг дахин боловсруулах саналтай байна.

Байнгын хорооны даргад энийг яаралтай хийхгүй бол бид нар хэцүү байдалд орно шүү гэдгийг мэргэжлийн хүний зүгээс санаа зовоод хэлж байна аа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Анар гишүүнтэй холбоотойгоор нэмж тайлбар мэдээлэл өгөх хүн байгаа юу? Үг хэллээ. Ерөнхийдөө саяын тэр кибер аюулгүй байдалтай холбоотой асуудлаар Байнгын хорооноос бид нар бол онцгойлж анхаарах ёстой. Манай гишүүн маань ч гэсэн энэ дээр санаа зовниод зарчмын санал гаргаж байгааг бол бүрэн дүүрэн дэмжиж байна.

Дараагийн Байнгын хорооны хурлаар бол ажлын хэсэг бол гаргаж ажиллая. Эрх зүйн орчныг шинэчлэх одоогийн байгаа хууль эрх зүйн орчин дээр тодорхой дүн шинжилгээ хийж Байнгын хорооноос тодорхой санал, дүгнэлт боловсруулах, хууль эрх зүйн асуудлаар тодорхой бодлого гаргах ийм ажлын хэсгийг бол гаргаж ажиллая гэсэн саналтай байна. Тэгээд дараагийн Байнгын хорооны хурлаар бол ажлын хэсгийн тогтоолын төслийг бол оруулж ирээд шийдээд явъя гэсэн ийм саналтай байна.

Тогтоолын төслийн 4 дүгээр заалттай холбоотойгоор гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Ингээд зүйл бүрээр нь тогтоолын төслийг бол хэлэлцэж дууслаа.

“Монгол Улсын 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хийсэн талаарх санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэх байгаа.

Ингээд хүрэлцэн ирсэн ажлын хэсгийнхэнд баярлалаа.

Хэлэлцэх асуудлыг хэлэлцэж дууслаа.

Эдийн засгийн байнгын хороонд танилцуулах гишүүнийг байнгын хорооноос томилох байгаа. Жангабыл гишүүн Эдийн засгийн байнгын хороонд байдаг уу? Жаргалан гишүүнээр тогтё. Жаргалан гишүүн Эдийн засгийн байнгын хороо танилцуулна.

Байнгын хороогоор хэлэлцэх асуудлуудыг хэлэлцэж дууслаа. Идэвхтэй оролцсон ажлын хэсэг болоод гишүүддээ баярлалаа. Ингээд Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье.

15.10 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА